



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024
ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**АВТО ЗАМЫН ЗАСВАР, ШИНЭЧЛЭЛТИЙН АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛ УДААШРАЛТАЙ БАЙНА.**

АУДИТЫН КОД: ОРА-2025/31-13-ШТА-ГА



Эрдэнэт хот
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, төргүүлэх
аудитор: П.Пүрэвлхагва

Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оргилмөрөн

Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn

Аудитор: О.Гантуяа

Утас: 70357955 Цахим хаяг: gantuyao@audit.gov.mn

Аудитор: Л.Болормаа

Утас: 70350757 Цахим хаяг: bolormaal@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх
хаягаар авна уу. Цахим хуудас www.audit.mn



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/13

Эрдэнэт

Аудитын тайлан баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.1, 1.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, аймгийн хэмжээнд нэгтгэн, үр дүнгийн талаар 2025 оны 12 дугаар сарын 10-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Б.Зоригтбаяр), Баян-өндөр сумын Засаг дарга (Б.Мөнхбаяр), Жаргалант сумын Засаг дарга (Л.Учрал) нарт зөвшөөрсүгэй.

4. Аудитын тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Баян-өндөр сумын Засаг дарга, Жаргалант сумын Засаг дарга нарт тус тус хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын менежер (Б.Буян-Ундрах), Ахлах аудитор (Г.Оргилмөрөн), аудитор (О.Гантуяа), (Л.Болормаа) нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

D:\my doc\bichig hereg\ tushaal\2025.doc

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	4
Хүснэгт, дүрслэлийн товьёг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүйн талаарх мэдээлэл	6
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ТӨЛӨВЛӨСНИЙ ДАГУУ БҮРЭН БҮРДҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.	9
1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хуулийн дагуу төлөвлөсөн боловч орлогын биелэлт, ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор 31,230.1 сая төгрөгийн орлогыг дутуу бүрдүүлсэн байна.	9
1.2 ОНХС-н төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа хангалтгүй, иргэдийн санал аваагүй зарим ТАХ-г төлөвлөж, ИТХ-аар баталсан байна.	13
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН АВТО ЗАМЫН ЗАСВАР, ШИНЭЧЛЭЛТИЙН ЗАРИМ АЖЛЫГ ҮР ДҮНТЭЙ, ҮР НӨЛӨӨТЭЙ, ХУГАЦААНД НЬ БҮРЭН ХАНГАЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.	21
2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримтлаагүй байна.	21
2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг аймгийн хэмжээнд нэгтгэн судалж, тооцоогүй байна.	28
2.3 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй авто замын ажлууд бүрэн дуусаагүй тул ашиглалт хангалтгүй, бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалттай бус байна.	31
БҮЛЭГ 3. ОНХС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВЬЖ БУЙ ХЯНАЛТЫН ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙГЭЭС ЗӨРЧИЛ ДУТАГДАЛ АРИЛАХГҮЙ БАЙНА.	34
3.1 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ТАХ-нд тодорхой түвшинд хяналт хэрэгжүүлж буй боловч гүйцэтгэлийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, хяналтыг үр дүнтэй, оновчтой хэрэгжүүлэх шаардлагатай байна.	34
3.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам, зааврын дагуу тайлагнаагүй байна.	36
АУДИТЫН ДҮГНЭЛТ:	39
ЗӨВЛӨМЖ:	40
Холбогдох байгууллагын санал:	41
Хавсралтууд:	42
Зөрчлийн нэгтгэл:	50

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТХ	Төсвийн тухай хууль
ТАХ	Төсөл арга хэмжээ
ИНХ	Иргэдийн нийтийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
БОЭТ	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХББЗА	Хот байгуулалт, барилга захиалагчийн алба
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
БХАТШББ	Бараа худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичиг
ГЕН	Гэрээний ерөнхий нөхцөл
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
УМС	Удирдлага мэдээллийн систем

Хүснэгт, дүрслэлийн товъёг

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1 ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл.....	9
Хүснэгт 2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох санхүүжилтийн хуваарь.....	10
Хүснэгт 3 Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг.....	11
Хүснэгт 4. Аймаг, сумдын ОНХС-д олгосон санхүүжилтийн гүйцэтгэл.....	11
Хүснэгт 5. Аймаг, сумын ОНХС-ийн өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл.....	11
Хүснэгт 6. Орхон аймгийн 20-оос дээш насны хүн амын тоо, ОНХС-д санал өгсөн иргэдийн тоо.	14
Хүснэгт 7 Болзолшгүй аваарын зардлын зарцуулалт	16
Хүснэгт 8 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ	16
Хүснэгт 9 Аймаг, сумын ОНХС-ийн чиг үүрэг.	19
Хүснэгт 10 Авто замын засвар, шинэчлэлтийн ажлын ХАА-ны үр дүн.....	22
Хүснэгт 11 Орхон аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт.	32
Хүснэгт 12 УМС-д ТАХ-ний хэрэгжилтийг оруулсан байдал.....	37

Дүрслэлийн товъёг

Дүрслэл 1 Сумдын ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-д иргэдийн санал авч, эрэмбэлсэн байдал.....	13
Дүрслэл 2 Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй төсөл арга хэмжээ ...	16
Дүрслэл 4 Чиг үүрэг (дүнгээр, хувиар).....	20
Дүрслэл 3 Чиг үүрэг (тоогоор)	20
Дүрслэл 5 Зохион байгуулсан ХАА-ны тоо	21
Дүрслэл 6 Зохион байгуулсан ХАА-ны дүн.....	21

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүйн талаарх мэдээлэл

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” А/107, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн хийж гүйцэтгэв.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-г байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.</p>
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Дээрх зорилтыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх• Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх• Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх
<p>Аудитын арга зүй</p>	<p>Аудитад аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний тамгын газар, холбогдох газар, хэлтэс, албадын аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамрууллаа.</p>
<p>Аудитын шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3200, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудит, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал” болон аудитыг чиглүүлж гаргасан бусад гарын авлагын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардлагатай бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалт хийж, холбогдох албан тушаалтнуудаас асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.</p>
<p>Аудитын шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, тогтоомж бусад эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:</p>

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

**Аудитын явцад
учирсан хүндрэл,
бэрхшээлүүд**

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- ✓ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал”
- ✓ Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- ✓ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- ✓ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- ✓ Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Г.Оргилмөрөн, аудитор О.Гантуяа, Л.Болормаа нар 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

Аудитын явцад хүндрэл, бэрхшээл үүсээгүй болно.

Үндсэн мэдээлэл:

Орон нутгийн хөгжлийн сангийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг.

Орон нутгийн иргэдийн оролцоотойгоор тухайн аймаг, сумын хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэрэгсэл бөгөөд иргэд нь өөрсдөө тус сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөлд оролцох боломжтой юм.

Төсвийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйлд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон ОНХС-ийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, хуваарилалтыг зохицуулсан бөгөөд ОНХС-ийн үйл ажиллагааны журмыг Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталжээ.

Монгол орны хөдөө орон нутагт нэн тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд засаглал болон иргэд олон нийтийн оролцоог сайжруулах зорилготой “Тогтвортой амьжиргаа 3” төслийг Олон Улсын Хөгжлийн Ассоциаци болон Монгол Улсын Засгийн газар хооронд 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан №5487-MN дугаартай санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу 2015-2023 онуудад амжилттай хэрэгжүүлж дууссан байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлд ОНХС болон улсын төсвөөс Орхон аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 34,710.3 сая төгрөгөөр баталсан байна.

ОНХС-ийн мэдээллийг иргэдэд үнэн зөв, түргэн шуурхай хүргэх зорилгоор “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс санхүүжүүлэн “Удирдлагын мэдээллийн систем”-ийг Сангийн яамны сайтад байршуулсан байна. Энэхүү системд ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг оруулахаар холбогдох журамд заажээ.

Үүний дагуу аймаг, сумын 2024 оны ОНХС-ийн мэдээллийг уг системд оруулсан байдлыг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөр хянахад мэдээлэл оруулалт хангалтгүй байна.

ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдэл аймгийн хэмжээнд 4,952.1 сая төгрөг, тайлант онд нийт 58,888.7 сая төгрөгийг төвлөрүүлж, 57,443.5 сая төгрөгийг зарцуулснаар эцсийн үлдэгдэл 6,397.3 сая төгрөг болсон байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ТӨЛӨВЛӨСНИЙ ДАГУУ БҮРЭН БҮРДҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хуулийн дагуу төлөвлөсөн боловч орлогын биелэлт, ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор 31,230.1 сая төгрөгийн орлогыг дутуу бүрдүүлсэн байна.

1.1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 1,230.1 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасан¹ эх үүсвэрээр Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санг төлөвлөж, тус сангаас Орхон аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар анх 33,099.6 сая төгрөгөөр баталсныг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн нэмэлт 1,610.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 34,710.3 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

Хүснэгт 1 ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөг)						
Д/д	ОНХС-ийн эх үүсвэр		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	ОНХНС-аас ОНХС-д олгох	Газрын тосны нөөц ашигласны төлбөр -30%	251.3	188.3	-63.0	74.9%
2	орлогын шилжүүлэг	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр -10%	32,402.1	31,235.0	-1,167.0	96.4%
3	Улсын төсвөөс ОНХС-д олгох	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр - 100 %	2.0	2.0	0.0	100.0%
4	орлогын шилжүүлэг	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр - 50%	107.4	107.4	0.0	100.0%
5	Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал		1,947.5	1,947.5	0.0	100.0%
Орхон аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн нийт дүн			34,710.3	33,480.2	-1,230.1	96.5%

Гүйцэтгэлээр улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг болон жилийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал бүрэн олгогдож, ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг буюу газрын тосны нөөц ашигласны төлбөрийг 63.0 сая, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 1,167.0 сая төгрөгөөр тус тус дутуу төвлөрүүлсэн байна.

Орхон аймгийн ОНХС-д 2023 онд ОНХНС-аас 16,970.4 сая төгрөг төлөвлөн гүйцэтгэлээр 16,782.3 сая төгрөг олгож байсан бол 2024 оны ОНХС-ийн эх үүсвэрийг өмнөх оноос 17,739.9 сая төгрөг буюу 105 хувиар нэмэгдүүлэн 34,710.3 сая төгрөг шилжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 33,480.2 сая төгрөгийн орлогыг шилжүүлсэн байна.

¹ Төсвийн тухай хуулийн 59.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. 59.1.2. Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь, 59.1.3. орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг, 59.1.5 газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.

Орлогын шилжүүлэг 96.5 хувьтай байгаа нь дээрх нөөцүүдийг ашигласны төлбөрийн орлого ОНХНС-д дутуу төвлөрсөнтэй холбоотойгоор аймгийн ОНХС-ийн орлогын шилжүүлгийг дутуу олгосон байна.

1.1.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг хууль журмаар баталсан аргачлалын дагуу хуваарилж, хугацааны хоцролттой олгосон байна.

Сангийн яамнаас ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь заалтын дагуу орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, холбогдох эх үүсвэр зэрэг шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн тооцсон байна.

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төсвийн хуваарь батлах тухай” 280 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарийг баталсан байна.

Хүснэгт 2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох санхүүжилтийн хуваарь

(сая.төгрөг)

Улирал	Санхүүжилт			Үнэлгээний урамшуулал		
	Хуваарь	Гүйцэтгэл	Зөрүү	Хуваарь	Гүйцэтгэл	Зөрүү
I	5,644.1	2,999.1	-2,645.0	354.1	0.0	0.0
II	8,493.6	9,006.6	513.0	531.1	0.0	0.0
III	8,493.6	6,469.8	-2,023.8	531.1	0.0	0.0
IV	10,131.5	13,057.2	2,925.7	531.2	1,947.5	0.0
Дүн	32,762.8	31,532.7	-1,230.1	1,947.5	1,947.5	0.0

Дээрхээс харахад I, III улиралд ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу олгоогүй, тасарсан, сумдын ОНХС-д олгох урамшууллыг мөн хуваарийн дагуу олгоогүй, IV улиралд нөхөж шилжүүлжээ.

1.1.3 Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас Баян-Өндөр сумын орон нутгийн хөгжлийн санд 1,210.6 сая төгрөг, Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн санд 19.5 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Аймгийн ОНХС-с сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээ зэрэг шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн тооцсон байна.

Дээрх тооцооллоор сумдад итгэлцүүрээр хуваарилагдах хөрөнгийн 60 хувь² буюу 19,592.0 сая төгрөгийг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу, 1,947.5 сая төгрөгийг жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр, 109.4 сая төгрөгийг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрөөр, нийт 21,648.9 сая төгрөг

² Төсвийн тухай хуулийн 59.2.2. энэ хуулийн 59.8-д зааснаас бусад хэсгийн 60 хувийг дараах итгэлцүүрийг харгалзан хуваарилах, 59.2.2.1. хүн амын тоо, 59.2.2.2. нутаг дэвсгэрийн хэмжээ, 59.2.2.3. ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

хуваарилахаар тооцож аймгийн ИТХ-ийн тогтоолын хавсралтаар³ тодотгон баталсан байна.

Хүснэгт 3 Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг

(сая төгрөг)

Д/д	Сумын нэр	Итгэлцүүрийн хуваарилалт				Гүйцэтгэлийн үнэлгээ	АМ-ын тусгай зөвшөөрлийн төлбөр	Сумдын ОНХС-д хуваарилагдах суурь дүн
		Ашигт малтмалын талбайн хэмжээ - 33%	Хүн амын тоо - 33%	Нутаг дэсвгэр - 34%	Итгэлцүүр нийт дүн			
1	Баян-Өндөр	2,110.7	6,257.4	1,965.4	10,333.5	925.6	31.6	11,290.7
2	Жаргалант	4,354.6	208.0	4,695.9	9,258.5	1,021.9	77.9	10,358.2
Дүн		6,465.4	6,465.4	6,661.3	19,592.0	1,947.5	109.4	21,648.9

ОНХС-аас Орхон аймагт олгосон орлогын шилжүүлгийг аймаг, сумын ОНХС-д харилцан адилгүй хуваарилж шилжүүлсэн байна.

Хүснэгт 4. Аймаг, сумдын ОНХС-д олгосон санхүүжилтийн гүйцэтгэл

(сая төгрөг)

Д/д	Сумын нэр	Итгэлцүүрээр олгох шилжүүлэг		Бусад		Нийт		
		Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Зөрүү
1	Аймаг	13,061.3	13,061.3	0.0	0.0	13,061.3	13,061.3	0.0
2	Баян-Өндөр	10,333.5	9,122.9	957.2	957.2	11,290.7	10,080.1	-1,210.6
3	Жаргалант	9,258.5	9,239.0	1,099.8	1,099.8	10,358.2	10,338.8	-19.5
Дүн		32,653.3	31,423.3	2,056.9	2,056.9	34,710.3	33,480.2	-1,230.1

* Нийт итгэлцүүрээр олгох шилжүүлгийн 40 хувь аймгийн ОНХС-д, 60 хувь нь сумдын ОНХС-д хуваарилагдана.

Дээрх хүснэгтээс харахад аймгийн ОНХС-ийн санхүүжилтийг бүрэн олгож, Баян-Өндөр сумын санхүүжилтийг 1,210.6 сая төгрөг, Жаргалант сумын санхүүжилтийг 19.5 сая төгрөгөөр тус тус дутуу олгосон байна.

Иймд гүйцэтгэлээр ОНХС-аас дутуу олгогдож буй санхүүжилтийг аймаг, сумын ОНХС-д харилцан тэгш хуваарилах бодлого барьж, хяналт тавих нь зүйтэй гэж үзлээ.

1.1.4 Аймгийн ОНХС-д “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас Засгийн газрын холбогдох шийдвэр болон хамтын ажиллагааны хүрээнд 55,361.0 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 25,361.2 сая төгрөг хүлээн авсан байна.

Аймаг, сумын ОНХС-ийн өөрийн орлогын эх үүсвэрийг дараах байдлаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 5. Аймаг, сумын ОНХС-ийн өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөг)

№	Сумын нэр	Эхний үлдэгдэл		Хандив, дэмжлэг		Бусад орлого		ТТХ-ийн 60.2.8 ⁴		Нийт эх үүсвэр	
		Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
1	Аймгийн төв	3,323.5	3,931.2	55,361.2	25,361.2	10.0	10.0	0.0	0.0	58,694.7	29,302.3

³ Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн Ээлжит бус XVIII хуралдааны 18/05 дугаар тогтоолын тавдугаар хавсралт. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас аймаг болон сумдын Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн тодотгосон хэмжээ.

⁴ Төсвийн тухай хуулийн 60.2.8. “малын тоо толгойн албан татварын орлого. ...”

2	Баян-Өндөр	716.8	716.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	716.8	716.8
3	Жаргалант	304.1	304.1	0.0	0.0	0.0	0.0	37.4	37.4	341.5	341.5
Нийт дүн		4,344.4	4,952.1	55,361.2	25,361.2	10.0	10.0	37.4	37.4	59,753.0	30,360.6

Дээрх хүснэгтээс харахад аймаг, сумын ОНХС-д эхний үлдэгдлээр 4,344.4 сая төгрөг бүрдүүлэхээр төлөвлөж, 4,952.1 сая төгрөг бүрдүүлжээ.

Монгол Улсын Ерөнхий сайд орон нутагт ажилласантай холбогдуулж танилцуулсан Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд Орхон аймагтай холбоотой дараах асуудлуудыг шийдвэрлэхээр тусгасан байна. Үүнд:

- Орхон аймагт ОНХС-ийн эх үүсвэрийг хорин тэрбум хүртэл нэмэгдүүлж нийтийн тээврийн автобусыг нэмэгдүүлж шинэчлэх
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын улсын төсөвт төвлөрүүлдэг эх үүсвэрээс тавин тэрбум хүртэлх төгрөгийг Орхон аймаг, Эрдэнэт хот доторх авто замын засвар, шинэчлэлтийн ажилд зориулан санхүүжүүлэх
- “Анхдагч илгээлтийн эзэд” ТББ-аас тавьсан хүсэлтийг судалж холбогдох арга хэмжээ авч ажиллах

Орхон аймаг, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн хоорондын хамтын ажиллагааны хүрээнд болон 2023 онд Монгол Улсын Ерөнхий сайд Орхон аймагт ажилласантай холбогдуулж “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас аймгийн ОНХС-д 2024 онд 55,361.2 сая төгрөг олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 25,361.2 сая төгрөг олгосон байна.

Үүнээс 50,000.0 сая төгрөг нь дээр дурдсан авто замын засвар, шинэчлэлтийн ажилтай холбоотой тусгагдсан бөгөөд ажлын гүйцэтгэлтэй уялдуулан 20,000.0 сая төгрөгийн санхүүжилт орж ирсэн байна.

Мөн аймгийн баяр наадмын худалдаа, үйлчилгээний орлогоос аймгийн ОНХС-д 10.0 сая төгрөг Жаргалант сумын ОНХС-д малын тоо толгойн албан татвараас 37.4 сая төгрөг төлөвлөж, тус тус төвлөрүүлсэн байна.

Баян-Өндөр сумын татварын орлогын төлөвлөгөөнд⁵ малд ногдуулах албан татварыг 7.6 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч ОНХС-ийн эх үүсвэрт оруулж батлаагүй, малын тоо толгойн албан татвараар 2024 онд 19.5 сая төгрөг бүрдүүлснийг сумын ОНХС-д төвлөрүүлээгүй, Жаргалант сум малын тоо толгойн албан татвараар 2024 онд 38.1 сая төгрөг бүрдүүлж, төлөвлөгөөнөөс давсан 0.8 сая төгрөгийг мөн ОНХС-даа төвлөрүүлээгүй байна.

- *Малын тоо толгойн албан татварыг Төсвийн тухай хуулийн 60.2.8⁶-н дагуу сумын ОНХС-д төвлөрүүлж, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.5-д заасан⁷*

⁵ Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 21/02 дугаар тогтоол. Баян-Өндөр сумын 2024 оны төсвийн тодотгол батлах тухай

⁶ Төсвийн тухай хуулийн 60.2.8-д “малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, ... зардалд зарцуулна.”

⁷ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.5. Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ. Үүнд: 4.5.1.Бэлчээрийн менежментийг сайжруулах, 4.5.2.Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;/хөдөөгийн хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, далан байгуулах, булгийн эхийг хашиж хамгаалах/, ... , 4.5.12. Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа.

төсөл арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулах зохицуулалттай тул дээрх 20.3 сая төгрөгийг сумдын ОНХС-д төвлөрүүлж алдаа, зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх талаар сумдын Засаг дарга нарт албан шаардлага хүргүүлэв.


1.2 ОНХС-н төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа хангалтгүй, иргэдийн санал аваагүй зарим ТАХ-г төлөвлөж, ИТХ-аар баталсан байна.

1.2.1 Сумдад иргэдийн санал аваагүй 6,275.6 сая төгрөгийн 119 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан нь нийт шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний 48.6 хувийг эзэлж байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог хангах, тухайн ТАХ-ний ач холбогдол, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлэх талаар Төсвийн тухай хуулийн 63.1⁸, 63.2⁹, 63.3¹⁰ дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын Тав¹¹, Зургаа¹² дугаар зүйлд заасны дагуу багийн түвшинд иргэдээс батлагдсан маягтын дагуу саналыг авч, багийн ИНХ-аар хэлэлцүүлэн эрэмбэлэн сумын ЗДТГ-т хүргүүлж, сумын Засаг дарга нарын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ТАХ-ний саналыг нэгтгэн, эрэмбийг танилцуулж, хэлэлцүүлсэн байна.

Сумын хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 6,275.6 сая төгрөгийн 119 ТАХ нь иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс үзнэ үү.)

Дүрслэл 1 Сумдын ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-д иргэдийн санал авч, эрэмбэлсэн байдал (сая төгрөг)



⁸ Төсвийн тухай хуулийн 63.1-д “Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна”

⁹ Төсвийн тухай хуулийн 63.2-д “Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны ИНХ-д гарсан саналыг ИНХ хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно”

¹⁰ Төсвийн тухай хуулийн 63.3-д “Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”

¹¹ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын “Тав. Баг, хорооны түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх”

¹² Дээрх журмын “Зургаа. Сум, дүүргийн түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх”

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх ТАХ-г Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.5¹³-д заасны дагуу урьдчилсан жагсаалт боловсруулж, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулалгүй төлөвлөлт хийсэн байна.

Харин эх үүсвэр нь шийдэгдсэн авто замын засвар, шинэчлэлтийн ажлууд, нийтийн тээврийн шинэчлэл болон аймгийн Засаг даргын иргэдтэй хийсэн уулзалтуудаас гарсан санал хүсэлтүүдийг харгалзан орон нутгийн төсөв боловсруулах үйл явцтай хамт ОНХС-аар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөсөн байна.

Орхон аймгийн хүн амын 2024 оны статистик тоо мэдээгээр 20-оос дээш насны 65,339 иргэн байгаагаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-нд нийт 15,245 иргэнээс санал авч эрэмбэлсэн байна.

Хүснэгт 6. Орхон аймгийн 20-оос дээш насны хүн амын тоо, ОНХС-д санал өгсөн иргэдийн тоо.

Баг, хороо	20-оос дээш насны хүн амын тоо	ОНХС-аар хэрэгжүүлэх ТАХ-д санал өгсөн иргэний	
		тоо	Хувь
Баян-Өндөр сум	63,141	13,379	21.2%
1-р баг, Зэст	3,420	378	11.1%
2-р баг, Оюут	4289	511	11.9%
3-р баг, Уурхайчин	3,436	468	13.6%
4-р баг, Хүрэнбулаг	3,969	592	14.9%
5-р баг, Уртбулаг	3,058	725	23.7%
6-р баг, Согоот	3,486	907	26.0%
7-р баг, Дэнж	3,244	400	12.3%
8-р баг, Бүрэнбүст	2,784	440	15.8%
9-р баг, Шанд	1,558	468	30.1%
10-р баг, Наран	2,020	433	21.4%
11-р баг, Цагаанчулуут	1,928	566	29.3%
12-р баг, Булаг	1,802	168	9.3%
13-р баг, Баянцагаан	3,085	454	14.7%
14-р баг, Говил	1,991	465	23.4%
15-р баг, Рашаант	2,623	560	21.4%
16-р баг, Малчин	389	283	72.7%
17-р баг, Эрдэнэ	2,989	233	7.8%
18-р баг, Баянбулаг	1,824	981	53.8%
19-р баг, Их залуу	2,325	739	31.8%
20-р баг, Даваат	2,363	887	37.6%
21-р баг, Уртын гол	1,791	536	29.9%
22-р баг, Яргуйт	1,879	575	30.6%
23-р баг, Найрамдал	1,806	490	27.1%
24-р баг, Чандмань	1,705	575	33.7%
25-р баг, Чингэл	1,399	194	13.9%
26-р баг, Баян-Овоот	1,978	350	17.7%
Жаргалант сум	2,198	1,866	84.9%
1-р баг, Улаантолгой	654	558	85.3%
2-р баг, Жаргалант	854	720	84.3%
3-р баг, Дулаан-Уул	690	588	85.2%
Нийт дүн	65,339	15,245	23.3%

¹³ Дээрх журмын 7.5-д “Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна”

Эндээс харахад аймгийн төвийн Баян-Өндөр сумын хувьд хөдөлмөрийн насны иргэдийн 21.2 хувиас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхөд санал авсан нь олон багтай, хүн амын тоо их, төвлөрсөн бүтэцтэй холбоотой байна.

Иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй ТАХ-ний тоо өндөр байгаа нь санал асуулгыг иргэдэд хүртээмжтэй, олон нийтийг хамруулж зохион байгуулаагүй, иргэд, олон нийтийн ойлголт муу, мэдээлэл дутмаг, идэвх оролцоо хангалтгүй байсан байна гэж үзлээ.

Нөгөө талаар иргэд, олон нийт ОНХС-ийн саналд идэвхтэй, ач холбогдол өгч оролцохоос илүүтэйгээр ИТХ-ийн төлөөлөгч нартаа хандаж хөрөнгө оруулалтын ТАХ-ний талаар санал хүсэлтэй илэрхийлж хүсэлт гаргах нь нийтлэг байна.

Иймд аудитаар Төсвийн тухай хуулийн 60.3.6¹⁴, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.5¹⁵, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2¹⁶ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.

1.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээний 92.1 хувь нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 101,702.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 496 ТАХ-г хэрэгжүүлэхээр 2024 онд санхүүжүүлэх 94,444.7 сая төгрөгийг төлөвлөж аймаг, сумын ИТХ-аас¹⁷ тодотгон баталсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-үүдийг Орхон аймаг, Эрдэнэт хотын “Ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2025”¹⁸, Орхон аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл¹⁹, аймгийн Засаг даргын 2020-2024²⁰ оны үйл ажиллагааны хөтөлбөртэй хэрхэн уялдсаныг үзэхэд 5,207.8 сая төгрөгийн 10 ТАХ нь эдгээр баримт бичгүүдэд тусгасан үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөр, зорилгод хамаарахгүй байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1,479.7 сая төгрөгийн 28 ТАХ нь мөн орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй байна.

¹⁴ Төсвийн тухай хуулийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”

¹⁵ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.5-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ”

¹⁶ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх”


¹⁷ Аймгийн ИТХ-н 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн Ээлжит бус XVIII хуралдааны 18/05 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт, Баян-Өндөр сумын ИТХ-н 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн Ээлжит XXI хуралдааны 21/02 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт, Жаргалант сумын ИТХ-н 2024 оны 09 дүгээр сарын 12-ний өдрийн Ээлжит бус IV хуралдааны 01 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт

¹⁸ Аймгийн ИТХ-н 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 13/01 дүгээр тогтоол

¹⁹ Аймгийн ИТХ-н 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Ээлжит II хуралдааны 02/01 дүгээр тогтоол

²⁰ Аймгийн ИТХ-н 2020 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн Ээлжит II хуралдааны 02/02 дугаар тогтоол

Дүрслэл 2 Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй төсөл арга хэмжээ



(Дэлгэрэнгүйг хавсралт №2-оос үзнэ үү)

Дээрх дүрслэлийн Жаргалант сумын 8 ТАХ-ний жагсаалтад болзошгүй аваарын зардал нэрээр 454.1 сая төгрөг баталж дараах 11 ТАХ-нд зарцуулжээ.

Хүснэгт 7 Болзолшгүй аваарын зардлын зарцуулалт

(сая төгрөг)			
Д/д	ТАХ-ний нэр	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт
1	Багуудын худаг засварлах ажил ЖС-А3-56 Гэрээ	18.4	18.4
2	Улаантолгой багийн Тасаг худаг засвар	13.9	13.9
3	Жаргалант сумын суваргатай толгой гэрэлтүүлэг	31.8	31.8
4	Ахмадын автобус авах	150.0	150.0
5	Улаантолгой багийн нутаг дэвсгэрт байрлах ногооны талбайд далан засвар	20.0	20.0
6	Жаргалант төвлөрсөн хог цэг ландфилл нүх цэвэрлэгээ	19.4	19.4
7	Жаргалант баг усны суваг хоолой солих ажил	16.3	16.3
8	2-р байрны дээвэр засвар	4.2	4.2
9	Жаргалант сумын суваргатай толгой цахилгаан эх үүсвэр тавих ажил	69.2	69.2
10	бранк байрны цахилгааны шит засварлах ажил	14.7	14.7
11	Найрамдлын хороололд цахилгааны 0,4 кв-ын шугам шинээр татах ажил	91.1	91.1
	Нийт дүн	449,116.6	449,116.6

Эдгээр нь гэнэтийн осол аваар, аюул, нэн даруй арилгах арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаа бус урьдчилан төлөвлөх боломжтой 11 ТАХ-г 449.1 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулан санхүүжүүлсэн байна.

1.2.3. Төсөвлөлтийн шаардлага хангахгүй буюу зураг, төсөв нь хийгдээгүй 42 ТАХ-нд 26,242.0 сая төгрөг төлөвлөж баталсан байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 496 ТАХ-г 94,444.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсны 94,167.0 сая төгрөгийн 323 ТАХ нь шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ байна.

Хүснэгт 8 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ

(сая төгрөг)									
Д/д	Аймаг, сум	Шилжих ХО		Шинээр эхлэх ХО		Төсөл хөтөлбөр		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

1	Аймгийн ОНХС	12	3,323.5	78	62,461.3	14	5,971.2	104	71,756.0
2	Баян-Өндөр сум	82	716.8	182	11,211.7	4	79.0	268	12,007.5
3	Жаргалант сум	55	109.1	63	10,494.0	6	78.1	124	10,681.2
	Нийт дүн	149	4,149.4	323	84,167.0	24	6,128.3	496	94,444.7

Аймгийн 2024 оны ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 40 ажлын зураг, төсвийг төсөв батлагдсанаас хойш ОНХО-аар нийт 1,071.4 сая төгрөгийн төсөвт өртгөөр ХАА-г зохион байгуулж 10 оролцогчтой 1,019.2 сая төгрөгийн гэрээ байгуулан хийлгэсэн байна.

Ажлыг зураг, төсөв хийлгээгүй авто замын завсар, шинэчлэлтийн эдгээр 40 ажилд аймгийн ОНХС-д нийт 25,233.1 сая төгрөг (Дэлгэрэнгүйг хавсралт №3-аас үзнэ үү), мөн зураг, төсөвгүйгээр Жаргалант сумын ОНХС-д “Улаантолгой багт цэцэрлэгт хүрээлэн байгуулах” ажилд 970.0 сая төгрөг, Баян-Өндөр сумын ОНХС-д “Эрдэнэ багийн 25-р гудамжинд автомашины гүүрэн гарц хийх” ажилд 38.9 сая төгрөг тус тус баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4²¹-д заасантай нийцэхгүй байна.

Өөрөөр хэлбэл ОНХС-аас 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудыг магадлалаар баталгаажсан зураг төсөвт үндэслэж төсвийг боловсруулж, төлөвлөж, батлуулаагүй байна.

Харин анх батлагдсан төсөвт өртөгтөө багтаан тухайн ажлын төсвийг салгуулж ХАА-г зарлах, зураг, төсөв хийгдсэний дараа төсвийн тодотголоор төсвийг нэмэгдүүлэх, нэмэгдсэн дүнгийн зөрүүгээр үлдэгдэл болон нэмэлт ажлын ТАХ-г тусад нь батлуулан ХАА зарлуулах зэргээр зохион байгуулсан байна. Тухайлбал:

- Орхон аймаг. Баян-Өндөр сум, Орон сууцны хороолол доторх авто замын зураг төсөл (Цагаанчулуут баг, Орон сууцны 7 дугаар хорооллын авто замын сүлжээг А/1002 авто замтай холбох) - ажлын магадлалын дүгнэлтээр /2023.12.15/ баталгаажсан нийт төсөв 3,997.1 сая төгрөг. Үүнийг батлагдсан төсөв 1,035.3 сая төгрөгт тааруулан замын төсвийг 992.0 сая төгрөгөөр салгаад холбооны сувагчлалын 43.3 сая төгрөгийг төсвийг нэмж тендер зарласан.
- Орхон аймаг. Баян-Өндөр сум, Орон сууцны хороолол доторх авто замын зураг төсөл (Оюут баг, Орон сууцны 2А хорооллын авто замыг А1001 болон Эрх чөлөөний өргөн чөлөөний авто замтай холбох) - ажлын магадлалын дүгнэлтээр /2023.12.15/ баталгаажсан нийт төсөв 4,742.8 сая төгрөг. Үүнийг батлагдсан төсөв 1,198.9 сая төгрөгт тааруулан 2022 онд боловсруулсан замын төсвийн 1,198.9 сая төгрөгөөр тендер зарласан.
- Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уртын гол баг. 260 айлын орон сууцны 0.28 км авто зам шинээр барих - ажлын магадлалын дүгнэлтээр /2024.05.31/ баталгаажсан нийт төсөв 674.4 сая төгрөг. Үүнийг батлагдсан 235.6 сая төгрөгийн төсөвт тааруулж 2024.06.12-нд төсөв гаргуулж тендер зарласан.
- Орхон аймаг. Баян-Өндөр сум. Яргуйт багийн "А" цэгээс "М" цэг хүртэлх 1.506 хатуу хучилттай авто зам - ажлын магадлалын дүгнэлтээр /2024.07.09/ баталгаажсан төсвийг мөн батлагдсан 859.7 сая төгрөгийн төсөв 2024.07.22-нд хийлгэж 2024.08.15-нд тендер зарласан.

²¹ Төсвийн тухай хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.”

- Орхон аймаг. Баян-Өндөр сум. Дэнж баг. Орон сууцны Баян-Өндөр, ББ парк хотхон орчмын хатуу хучилттай авто зам шинээр барих – ажлын магадлалын дүгнэлтээр /2024.06.07/ баталгаажсан төсвийг батлагдсан төсөвт тааруулж 2,057.9 сая төгрөгөөр төсөв салгаж 2024.07.26-нд тендер зарласан.
- Орхон аймаг. Баян-Өндөр сум. Зэст баг. БОЭТ-ийн авто зогсоол , авто замд их засварын ажил хийх – тус ажилд анх 1,608.3 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд батлагдсан төсвөөр ХАА-г зохион байгуулж гүйцэтгэгчийг шалгаруулаад магадлалын дүгнэлтээр төсөв нь нэмэгдэж баталгаажсан тул төсвийн тодотголоор төсвийг 1,842.0 сая төгрөг болгон нэмэгдүүлж гэрээ байгуулсан гүйцэтгэгчтэй 223.7 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан.

Дараах 8 ТАХ-ний төсөвт өртгийг төсвийн тодотголоор нэмэгдүүлж, нэмэгдсэн дүн нь анх батлагдсан төсөвт үндэслэж төсөв салгаж тендер зарлаж байгуулсан гэрээний үнийн дүнгийн 15 хувиас өндөр тул нэмэлт тендер зарласнаас оны эцэсийн дүнгээр 5 ХАА-г амжилттай зохион байгуулсан, 3 ХАА амжилтгүй болсон байна. Үүнд:

- ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Эрдэнэ баг. 20-р сургуулийн гадна талд хатуу хучилттай авто зогсоол шинээр барих /үлдэгдэл хэсэг /
- ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Булаг баг. Наран багийн 74-р гудамжны уулзвараас Булаг багийн уулзвар хүртэлх авто замд их засварын ажил хийх. /үлдэгдэл хэсэг/
- ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Оюут баг. Барилгачдын талбайн уулзвараас зүүн тийш 0.31 км авто замд их засварын ажил хийх /үлдэгдэл хэсэг /
- ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уурхайчин баг. Сувиллын хойд талын авто замаас ДГТ 3-3-р байр хүртэлх авто зам , авто зогсоолд их засварын ажил хийх /үлдэгдэл хэсэг /
- ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Баянбулаг баг. 18-р цэцэрлэгийн авто зогсоолд их засварын ажил хийх /үлдэгдэл хэсэг/
- ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Оюут баг. Отгонбилэгийн гудамжны төв замаас 28,34-р байрны авто зогсоол , авто замд их засварын ажил хийх - амжилтгүй
- ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уурхайчин баг. Үйлчилгээний төвийн баруун зүүн талын авто зам ,авто зогсоолд их засварын ажил хийх /үлдэгдэл хэсэг / - амжилтгүй
- ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уурхайчин баг. Уурхайчны гудамжийг А1001 замтай холбосон авто замд их засварын ажил хийх /үлдэгдэл хэсэг/ - амжилтгүй

Дараах 4 ТАХ-ний төсөвт өртөг нэмэгдсэн дүнгээр төсвийн тодотголоор тусад нь ТАХ төлөвлөсөн байна.

- ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уурхайчин баг. Уурхайчны тойргийн хэсгийн авто замд их засварын ажлын үлдэгдлийг хийх
- ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Рашаант баг. 26-р цэцэрлэгийн баруун талын уулзвараас Халуун усны уулзвар хүртэлх авто замд нэмэлт 3 см-ийн хучилтыг хийх
- ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Их залуу баг. 15-р сургуулийн баруун талын уулзвараас халуун усны уулзварын авто замд нэмэлт 3 см-ийн хучилтыг хийх
- ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Яргуйт баг. А1002 замын уулзвараас 15-р сургуулийн баруун талын уулзвар хүртэлх авто замд нэмэлт 3 см-ийн хучилтыг хийх

Эдгээр нь замын ажлын гүйцэтгэлийг удаашруулах, олон дахин зам хаах нөхцөл байдлыг бий болгох, иргэдийг бухимдуулах, цаг хугацаа алдах, замын ажлын чанарт нөлөөлөх эрсдэл, үр дагаврыг бий болгож байна.

Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр 2023 онд тендер зарлаж 4,763.5 сая төгрөгөөр гэрээ байгуулсан “Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцаар хангах” ажилд 2024 оны төсвийг батлахдаа гадна тохижилттой холбоотой 210.5 сая төгрөг, зураг, төсөвт тусгагдаагүй ажлуудтай холбоотойгоор нэмж 714.5 сая төгрөг баталж гүйцэтгэгчтэй 714.5 сая төгрөгийн нэмэлт байгуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.7²²-д заасантай нийцэхгүй байна.

1.2.4 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хууль, журмаар тогтоосон чиг үүрэгт хамаарах ТАХ-г хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3²³ дахь хэсэгт заасан ОНХС-ийн хөрөнгийг зарцуулахыг хориглосон зүйлд хамаарах ТАХ-г аймаг, сумын ОНХС-ийн төлөвлөлтөд тусгаагүй байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 339 төсөл арга хэмжээнд 57,443.5 сая төгрөгийг журамд заасан дараах чиг үүргүүдэд зарцуулжээ.

Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг журамд заасан чиг үүргээр харуулбал:

Хүснэгт 9 Аймаг, сумын ОНХС-ийн чиг үүрэг.


Д/д	Журамд заасан чиг үүрэг	Орхон		Баян-Өндөр		Жаргалант	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэн ухаан, цахим технологи	12	5,476.9	53	1,811.0	13	258.8
2	Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ	50	27,676.6	51	3,621.3	26	5,849.6
3	Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах	22	3,295.1	39	1,568.9	25	2,937.7
4	Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах	1	270.9	2	219.7	10	70.6
5	Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах					1	18.0
6	Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх			2	52.2	8	360.4
7	Өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт	1	133.2		0.0		
8	Ажлын байр бий болгох		0.0	7	386.0		

²² Төсвийн тухай хуулийн 29.7-д “Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн тохиолдолд түүнийг тухайн жилийн төсвийн тодотголд тусган өөрчилнө” гэж заасантай нийцэхгүй байна.


²³ Төсвийн тухай хуулийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.1-д “орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ”, 60.3.2-д “улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага”, 60.3.3-д “үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал”, 60.3.4-д “нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа”, 60.3.5-д “зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах”

9	Журамд заасан чиг үүрэгт хамааралгүй	6	3,245.9			
10	Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа			10	190.8	
Нийт дүн		92	40,098.6	164	7,849.8	83

Дүрслэл 4 Чиг үүрэг (тоогоор)



Дүрслэл 3 Чиг үүрэг (дүнгээр, хувиар)



Дээрх графикаас харахад аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр дараах ажлуудыг голчлон хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээний 127 ажилд 68.5 хувийг,
- Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах 86 ажилд 14.4 хувийг,
- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэн ухаан, цахим технологийн 78 ажилд 13.9 хувийг тус тус зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор²⁴ Орхон аймгийн Баяр наадам, Эрдэнэт хот, Эрдэнэт үйлдвэрийг бүтээн босгосон Илгээлтийн эзэд -50 жилийн ойн баярыг, Хангайн бүсийн - 2024 оны хурдан морины уралдаантай хамтатган зохион байгуулахтай холбоотойгоор нийт 6 ТАХ-нд 3,245.9 сая төгрөг зарцуулсан байна.

²⁴ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 233 дугаар тогтоол.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН АВТО ЗАМЫН ЗАСВАР, ШИНЭЧЛЭЛТИЙН ЗАРИМ АЖЛЫГ ҮР ДҮНТЭЙ, ҮР НӨЛӨӨТЭЙ, ХУГАЦААНД НЬ БҮРЭН ХАНГАЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.


2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримтлаагүй байна.

2.1.1 Сангийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн зарим заалтуудыг зөрчин зохион байгуулсан, сумд шинээр хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээний 50 хувийг шууд худалдан авалтаар буюу хэт жижиглэсэн байдлаар төлөвлөсөн байна.


Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 83,447.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 341 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 82,871.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 332 ТАХ-ний худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр амжилттай зохион байгуулсан ТАХ-ний худалдан авах ажиллагааны аргыг дүрслэлээр харуулбал.

Дүрслэл 6 Зохион байгуулсан ХАА-ны тоо



Дүрслэл 5 Зохион байгуулсан ХАА-ны дүн



Дээрхээс харахад нээлттэй тендер шалгаруулалтын аргаар нийт 74,127.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 109, харьцуулалтын аргаар 6,633.5 сая төгрөгийн 100, гэрээ шууд байгуулах аргаар 29.9 сая төгрөгийн 1, шууд худалдан авалтаар 2,080.9 сая төгрөгийн 122 төсөл арга хэмжээний ХАА-г тус тус амжилттай зохион байгуулжээ.

Аймаг, сумдын зохион байгуулсан ХАА-тай холбоотойгоор гарсан санал гомдлыг дараах байдлаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

Орхон аймгийн ХААГ-аас зохион байгуулсан Эрдэнэ багт шинээр гэрэлтүүлэг хийх – 288.8 сая төгрөг, Оюут багийн төрийн үйлчилгээний нэгдсэн төв барих – 3,142.0 сая төгрөг, Булаг баг. 25-р гудамжны тоглоомын талбайг тохижуулах – 172.0 сая төгрөг ТАХ-ний ХАА-нд оролцогчдоос гаргасан гомдлыг Сангийн яамнаас

хянаад захиалагчийн шийдвэр үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бөгөөд Орхон аймгийн Баян-Өндөр сумын хэмжээнд авто замын хэвтээ тэмдэглэгээ хийх – 910.6 сая төгрөгийн ажлыг захиалагчийн шийдвэр үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн тул ХАА-г дахин зарлан зохион байгуулсан байна.

Баян-Өндөр сумын зохион байгуулсан 899.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-ний ХАА-нд оролцогчдоос гаргасан гомдлыг Сангийн яамнаас хянан үзэж үнэлгээг дахин хийлгэхээр шийдвэрлэжээ.

- 20-р сургуульд биеийн тамирын онооны самбар, лед дэлгэц, тоног төхөөрөмж худалдан авах – 30.0 сая төгрөг
- Дэнж баг. Баруун Дэнжид дэд станц АТП барих – 90.0 сая төгрөг
- Баянцагаан баг. ПДУ-ийн Гэр хороололд баригдсан цэвэр, бохир усны шугамаас салбар шугам үргэлжлүүлэн татах /Баянцагаан/ - 469.0 сая төгрөг.

Үнэлгээний хороо дээрх ажлуудын тендерийг дахин хянаж гомдол гаргасан оролцогчийн ирүүлсэн тендерийг шалгаруулсан байна.

Уртбулаг баг. 5-р хорооллын 24-р байрны нүхэн граж дээрх хүүхдийн тоглоомын талбай байгуулах /21-р байрны ард авто зогсоол хийх/ - 310.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд захиалагчийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

Жаргалант сумын зохион байгуулсан Ургийн гажгийг эрт оношлох ЭХО аппарат худалдан авах - 150.0 сая төгрөгийн ТАХ-ний ХАА-нд гаргасан гомдлыг Сангийн яамнаас хянаад захиалагчийн шийдвэр үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн тул тендерийн баталгааны 0.7 сая төгрөгийг улсын орлого болгосон, Ногоон- Жаргалант хөтөлбөрийн хүрээнд 50 ковш худалдан авах - 200.0 сая төгрөгийн ХАА-ны тендерийг дахин үнэлэх шийдвэр гаргасны дагуу үнэлгээний хороо үнэлгээг дахин хийж гомдол гаргагчийг шалгаруулсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр багуудад шинээр гэрэлтүүлэг хийхээр зарласан нийт 15 ажлын тендерийн үр дүнгээр 632.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8-н ажлыг Агуут-Ажнай ХХК 511.8 сая төгрөгөөр, 1,376.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5-н ажлыг Сервис по сименс ХХК 1,159.2 сая төгрөгөөр гүйцэтгэхээр тус тус шалгарч гэрээ байгуулсан байна.

Мөн аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр 2024 онд авто замын засвар, шинэчлэлтийн нийт 59 ажлын тендерийг зарлан зохион байгуулсан үр дүнгээр дараах компаниуд шалгарч гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 10 Авто замын засвар, шинэчлэлтийн ажлын ХАА-ны үр дүн

(сая төгрөг)

Д/д	Гүйцэтгэгчийн нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Ажлын тоо	Тайлбар
1	Жи пи экспресс финанс ХХК	14,112.3	13,926.7	19	Тод тунгалаг тэмдэг ХХК-ийн шалгарсан ажилд гомдол гарсантай холбоотойгоор ХАА-г 2025 онд үргэлжлүүлэн 2 удаа зохион байгуулж тус компани 895.8 сая
2	Энх-Алтаргана ХХК	2,059.3	1,881.5	8	
3	Жавхлан харгуй ХХК	5,727.2	5,592.2	7	
4	Хүчит зам ХХК	4,560.4	4,287.4	7	
5	Эрхэм нөхөр ХХК	2,244.6	2,168.5	6	
6	Баянцогт зам ХХК	2,426.7	2,372.8	4	
7	Ингүүмэл зам ХХК	3,283.8	3,091.0	4	
8	Дагинас хайрхан ХХК	1,375.4	1,317.0	2	

9	Шилдэг зам ХХК	13,453.7	13,344.3	1	төгрөгөөр гүйцэтгэхээр дахин шалгарсан.
10	Тод тунгалаг тэмдэг ХХК	910.6	876.7	1	
Нийт дүн		50,154.0	48,858.1	59	

Дээр хүснэгтээс харахад Жи пи экспресс финанс ХХК нь 19 ажилд /13,926.7 сая төгрөг/, Энх-Алтаргана ХХК 8 ажилд /1,881.5 сая төгрөг/, Жавхлан харгуй ХХК 7 ажилд /5,592.2 сая төгрөг/, Хүчит зам ХХК 7 ажилд /4,287.4 сая төгрөг/, Эрхэм нөхөр ХХК 6 ажилд /2,168.5 сая төгрөг/ тус тус гүйцэтгэгчээр шалгарсан байна.

Аудитаар ХАА-тай холбоотой дараах алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

- Орхон аймаг. Баян-Өндөр сум. Наран баг. 74-р гудамжны уулзвараас хорооллын эцэс хүртэлх авто замд их засварын ажил хийх тендерт шалгарсан Ингүүмэл зам ХХК-ийн ирүүлсэн үнийн хөнгөлөлт тооцсон үнэ болох 1,516.2 сая төгрөгийн үнийн саналыг /цахим системд тооцсон/ үнэлгээний хороо үнийн хөнгөлөлтийг хасаагүй дүнгээр уг тендерт шалгаруулах дүгнэлт гаргаснаар Ингүүмэл зам ХХК-тай БЗА-136/24 дугаартай гэрээг 1,525.2 сая төгрөг буюу үнийн саналаас 9.0 сая төгрөгөөр илүү дүнгээр байгуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1²⁵, ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 27.2.1²⁶, 48.2.3²⁷, 50.10²⁸-д заасантай нийцэхгүй тул төлбөрийн акт тогтоов.
- Жаргалант сумын ОНХС-ийн 2024 оны төсөвт²⁹ “Улаантолгой багт цэцэрлэгт хүрээлэн байгуулах” ажилд 970.0 сая төгрөгийн төсөвт өртөг баталсан ч ХАА-г 1,290.2 сая төгрөгөөр тендер зарлан 1,282.7 сая төгрөгийн үнээр гүйцэтгэгчийг шалгаруулан 2024 онд 970.0 сая төгрөг, 2025 онд 312.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр ЖС-17/24 дугаартай гэрээг байгуулсан байна.
- Жаргалант сумын ОНХС-ийн 2024 оны төсвийн тодотголоор “Малжуулах хөтөлбөрийн хүрээнд: ХААЯ-аас 50% 2024 онд 50% 2025 онд шилжүүлэх нөхцөлтэйгээр шууд гэрээгээр Трактор 50 морины хүчтэй, дискэн хадуур, тармуур худалдан авах” нэртэй ТАХ-нд 29.9 сая төгрөг баталж тендер шалгаруулалтгүйгээр “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-аас 114.9 сая төгрөгөөр “Хөдөө аж ахуйн техник худалдах, худалдан авах” 20244462119126 дугаартай, гэрээнд тоног төхөөрөмжийн үлдэгдэл төлбөрт жилийн 5 хувийн хүү төлөх зохицуулалттай, гэрээ байгуулжээ.
- Жаргалант сумын ОНХС-ийн ТАХ-ний жагсаалтад баталсан болзошгүй аваарын зардлаас тендер сонгон шалгаруулалтгүйгээр 150.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулан автобус худалдан авсан байна.

²⁵ Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”

²⁶ ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 27.2-д “Тендерийн нээлтэд зарлагдсан тендерийн үнэ, үнийн хөнгөлөлтөд үндэслэн харьцуулах үнийг дараах байдлаар тооцно”, 27.2.1-д “үнийн хөнгөлөлтийг оролцогчоос ирүүлсэн аргачлалын дагуу тооцох, аргачлал ирүүлээгүй бол тендерийн үнээс тооцох”

²⁷ 48.2-д “Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. 48.2.3.үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих”

²⁸ 50.10-д “Үнэлгээний хорооны дарга үнэлгээний хорооны үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, хурлыг товлох, тогтоосон хугацаанд шуурхай шийдвэр гаргаж, захиалагчид хүргүүлэх, үнэлгээний хороог захиалагчийн өмнө төлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлнэ”

²⁹ Жаргалант сумын 2024 оны төсөв батлах тухай сумын ИТХ-ийн 2023 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 01 дугаар тогтоол, тодотгосон төсөв батлах тухай 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дугаар тогтоол

- Эдгээр нь ТБОНӨХБАҮХТухай хуулийн 10.2³⁰, 18.1³¹, 35.2³², 44.1³³, 48.2.1³⁴-д заасантай нийцэхгүй тул Жаргалант сумын Засаг даргад албан шаардлага өгөв.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх “Орхон аймаг. Баян-Өндөр сумын 6 дугаар бичил хорооллын уулзвараас Их залуу багийн уулзвар хүртэлх А1002 дугаартай улсын чанартай авто замыг 4 эгнээ болгож өргөтгөн шинэчлэх ажил”-ын зураг, төсөвт 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр хийсэн магадлалын дүгнэлтээр нийт төсвийг 20,130.2 сая төгрөгөөр баталгаажуулсан байна.

Дээрх ажлыг гүйцэтгэхэд зориулж аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ-ний жагсаалтад 13,453.7 сая төгрөг баталж³⁵, аймгийн ХБТХОХ-с ирүүлсэн 13,268.9 сая төгрөгийн хяналтын төсвийг хавсарган ХАА-г зарласан байна. Хяналтын төсөвт уг ажлын инженерийн нарийвчилсан зураг төсөв боловсруулах ажлын гэрээний (ЗТ-01/23) үнэ болох 71.7 сая төгрөгийг тусгаагүй байна.

Энэхүү ажлын тендер Шилдэг зам ХХК ганцаараа оролцож 13,344.3 сая төгрөгийн үнийн санал ирүүлж шалгарсан байна.

Шилдэг зам ХХК-ийн ирүүлсэн үнийн саналд хяналтын төсөвт тусгагдаагүй зураг төслийн зардлыг 184.8 сая төгрөгөөр тооцон тусгасан, захиалагчийн болон зохиогчийн хяналтын зардлыг орхигдуулсан, хяналтын төсвөөс 75.4 сая төгрөгөөр өндөр үнийн санал ирүүлсэн ч шаардлага хангасан тендерээр шалгаруулсан байна.

Энэ нь Захиалагчийн баталсан ОРАХААГ/20240101122 тендер шалгаруулалтын дугаартай ТББ-ийн ТӨХ-ийн ТШЗ 19.1-ийн 3-д “Төсөвт холбогдох зардлуудыг норм нормативын дагуу бүрэн гүйцэд тооцох ба зураг төслийн зардлыг хяналтын төсөвт тусгаснаар шууд тооцож ирүүлнэ” гэж заасан шаардлагыг хангахгүй тул ТБОНӨХБАҮХА-ны тухай хуулийн 5.1³⁶, 26.9³⁷, 26.10.1³⁸, 28.1.3³⁹-д заасантай нийцэхгүй байна.

³⁰ 10.2-д “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”

³¹ 18.1-д “Захиалагч энэ хуулийн 10.2-т заасан шууд худалдан авч болох төсөвт өртгөөс дээш тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангана”

³² 35.2-д “гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ”

³³ 44.1-д “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”

³⁴ 48.2-д “Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ”, 48.2.1-д “худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах”

³⁵ Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 17/04 дүгээр “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоолын 5 дугаар хавсралт

³⁶ 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”

³⁷ 26.9-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ”

³⁸ 26.10-д “Энэ хуулийн 26.9-д зааснаас бусад тендер болон дараах тендерийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана”, 26.10.1.тендерийн үнэ төсөвт өртгөөс, эсхүл энэ хуулийн 10.11-д заасан болон ерөнхий гэрээний нэгж дээд үнээс хэтэрсэн

³⁹ 28.1.3-д “шаардлагад нийцээгүй тендер ирүүлсэн оролцогчийн тендерээс татгалзах”

Гэрээ байгуулахтай холбогдуулан ХББЗА ОНӨААТҮГ-аас ХААГ-т хандан хяналтын төсөвт тусгагдсан захиалагч, зохиогчийн хяналтын зардлуудыг тендерийн төсөвт тусгаагүй, зураг төсвийн үнийн зардал 184.8 сая төгрөг оруулсан асуудлыг яаралтай шийдвэрлэж өгөх талаар 2024.04.25-ний өдрийн 234 дугаар албан бичиг ирүүлж, Шилдэг зам ХХК-аас 2024.04.30-ны өдрийн 24/45 дугаар албан бичгээр тухайн тендерийн материалд тусгасан үнийн саналын задаргаа буюу барилга угсралтын ажлын төсвийг боловсруулахдаа барилга захиалагчийн хяналтын зардал болон зураг төсөл зохиогчийн зардлыг орхигдуулсан тул үнийн саналыг өөрчлөхгүйгээр эдгээр зардлуудыг нийт 119.0 сая төгрөгөөр тооцон тусган гэрээг байгуулах талаар ирүүлсэн хүсэлтийн дагуу дээрх зардлуудыг тус тус тусган гэрээ байгуулсан байна.

Орхон аймаг. Баян-Өндөр сумын 6 дугаар бичил хорооллын уулзвараас Их залуу багийн уулзвар хүртэлх А1002 дугаартай улсын чанартай авто замыг 4 эгнээ болгож өргөтгөн шинэчлэх ажлын гэрээ байгуулагдсаны дараа гэрээний үнийн дүнд орсон техник, технологийн хяналтын 316.1 сая төгрөгийн зардлаар техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний тендерийг зарлаж Мөнхөд ашдын зам ХХК-тэй 296.9 сая төгрөгийн гэрээ байгуулан ажилласан байна.

Мөн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 31 байршилд хийгдэх авто зам, засварын ажлын төсөвт тусгагдсан захиалагчийн хяналтын зардлаас 237.5 техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний тендер зарлаж Ар си эс си ХХК-г шалгаруулан 230.0 сая төгрөгийн гэрээ байгуулан ажилласан байна.

2.1.2 Нийт төлөвлөсөн төсөл арга хэмжээний 98 хувьтай гэрээ байгуулж, 81 хувийг бүрэн хэрэгжүүлсэн, зарим ТАХ-ний гүйцэтгэлийн санхүүжилтийг илүү олгосон байна.

Аймгийн хэмжээнд тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр шинээр болон он дамжуулан хэрэгжүүлэх нийт 101,702.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 496 ТАХ-нд 94,444.7 сая төгрөг төлөвлөж баталснаас 486 ТАХ-нд 100,796.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан, 681.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ-г огт хэрэгжүүлээгүй байна.

Үүнээс 40,953.7 сая төгрөгийн 402 ТАХ бүрэн хэрэгжсэн, 52,108.8 сая төгрөгийн 84 ТАХ дутуу хэрэгжсэн бөгөөд эдгээр он дамжин хэрэгжиж буй ТАХ-нд нийт 19,889.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Гэрээ байгуулсан ТАХ-с 339 ТАХ-ний дундын болон эцсийн санхүүжилтэд нийт 57,443.5 сая төгрөг зарцуулсан байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой дараах алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

- *31 байршилд хийгдэх авто зам, засварын барилгын ажлын техник технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний ЗТБ-60/24 дугаартай гэрээ байгуулан замын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй Ар си эс си ХХК-д 13 ажил тус бүрийн гэрээнд тусгасан захиалагчийн хяналтын зардлыг хэтрүүлж буюу тухайн ажлын хувьд гэрээний дүнг хэтрүүлэн нийт 2.2 сая төгрөг илүү олгосон байна.*
- *Захиалагчийн техник хяналтын зардлыг техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид олгосонтой давхардуулан нийт 15 төсөл арга хэмжээний 124.1 сая төгрөгийн орон нутгийн техник хяналтын дансанд илүү шилжүүлсэн байна.*

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 41.2.3⁴⁰, Сангийн сайдын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2.9⁴¹-д заасантай болон ажил тус бүрийн гэрээний 1.2-д тусгасан гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна гэсэн зохицуулалттай нийцэхгүй байх тул төлбөрийн акт тогтоов.

- Орхон аймгийн Баяр наадам, Эрдэнэт хот, Эрдэнэт үйлдвэрийг бүтээн босгосон Илгээлтийн эзэд - 50 жилийн ойн баярын хүрээнд ахмадуудад олгосон урамшууллыг 103 иргэнд 13.5 сая төгрөг давхардуулан илүү олгосон байна.
- Орхон аймгийн Баяр наадам, Эрдэнэт хот, Эрдэнэт үйлдвэрийг бүтээн босгосон Илгээлтийн эзэд - 50 жилийн ойн баяр наадмаар цэргийн ёслол, зочин төлөөлөгч хүлээн авах шатахууныг 0.3 сая төгрөгийн анхан шатны баримтгүй зарцуулсан байна. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6.4.1⁴²-д, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1⁴³, 13.7⁴⁴-д заасантай нийцэхгүй тул төлбөрийн акт тогтоов.
- Нийтийн тээврийн автобус худалдан авах ТАХ-ний Боса импекс ХХК-тай байгуулсан гэрээний хугацааг өмнө нь 1 удаа сунгасан асуудлаар хууль болон гэрээний зохицуулалтыг зөрчин үндэслэлгүйгээр 2 дахь удаагаа дахин сунгаснаар 26.8 сая төгрөгийн алданги тооцох нөхцөлийг хүчингүй болгосон байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 40.2.1⁴⁵, ОРАХААГ/20240102191 дугаартай БХАТШББ гэрээний ерөнхий нөхцөлийн 2.8⁴⁶, 2.9⁴⁷, гэрээний 3.5⁴⁸-д заасантай нийцэхгүй байх тул зөвлөмж өгөв.
- Орхон аймаг. Баян-Өндөр сум. Зэст баг. БОЭТ-ийн авто зогсоол, авто замд их засвар хийх ажлыг гүйцэтгүүлэхээр Хүчит зам ХХК-тай байгуулсан БЗА-114/24 дугаартай гэрээний үнийн дүнгийн 30 хувь болох 478.96 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр олгосон хэдий ч тухайн гүйцэтгэгчид давуу байдал үүсгэж, урьдчилгаа төлбөрийг тооцохгүйгээр 368.8 сая төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилтийг дахин нэмж олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.3, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар

⁴⁰ Төсвийн тухай хуулийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”

⁴¹ Сангийн сайдын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 2.2.9-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийн хяналтыг хэрэгжүүлэх, хянан баталгаажуулах”

⁴² Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”

⁴³ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”

⁴⁴ 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”

⁴⁵ ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 40.2-д “Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно”, 40.2.1.энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

⁴⁶ БХАТШББ-ийн ГЕН-ийн 2.8-д “Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно”

⁴⁷ 2.9-д “ГЕН-ийн 2.7.2-т /гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл/ заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй”

⁴⁸ Нийтийн тээврийн автобус худалдан авах ОРАХААГ/20240102191 дугаартай гэрээний 3.5-д “Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно. Хүсэлтийг дараах нөхцөл байдал /захиалагч баримт мэдээлэл гаргаж өгөх үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл/ үүссэн тохиолдолд нотлох баримтын хамт гэрээний хугацаа дуусахаас өмнө ажлын 5 хоногийн дотор захиалагчид бичгээр ирүүлнэ”

хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.14⁴⁹-д заасныг зөрчсөн байх тул албан шаардлага хүргүүлэв.

- *Жаргалант сум. Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцаар хангах төсөл арга хэмжээний 2 гүйцэтгэгчийн /үндсэн барилга Сигма-Эс ХХК – 273.9 сая төгрөг, гадна тохижилт Талст-Өргөө ХХК – 10.4 сая төгрөг/ чанарын баталгааны нийт 284.3 сая төгрөгийг баталгааны хугацаа дуусаагүй байхад гүйцэтгэгчид олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.3, Барилгын тухай хуулийн 14.3⁵⁰, 14.4⁵¹, 14.5⁵²-д захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ЖС-12/23 дугаартай гэрээний 4.9⁵³-д заасантай нийцэхгүй байх тул төлбөрийн акт тогтоов.*
- *Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ-ний жагсаалтад зураг төсөл хийлгэх зардал батлагдаагүй байхад тайлант онд шууд гэрээ байгуулан зураг төслийн зардалд нийт 223.6 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.2⁵⁴, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын 3.4.1⁵⁵-д заасантай нийцэхгүй байх тул албан шаардлага хүргүүлэв.*

Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн санхүүжилтийн эрхийг аймгийн ЗДТГ-н СТСХ-ээс олгож байгаа нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын 8.5⁵⁶ дахь заалттай, сумдын ОНХС-н төлбөрийн хүсэлтэд 2-р гарын үсгийг санхүүгийн албаны дарга нар зурж буй нь журмын 8.6⁵⁷ дахь заалттай тус тус нийцэхгүй байна

⁴⁹ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.14-д “Урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгосон төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг олгохдоо урьдчилгаа төлбөрийн баталгааг гүйцэтгэлээр бүрэн чөлөөлсний дараа олгоно”

⁵⁰ Барилгын тухай хуулийн 14.3-д “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна”

⁵¹ 14.4-д “Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ”

⁵² 14.5-д “Энэ хуулийн 14.4-т заасны дагуу зөрчлийг арилгаснаар энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсонд тооцно”

⁵³ ЖС-12/23 дугаартай гэрээний 4.9-д “Барилгын тухай хуулийн 14.8 дахь заалтын дагуу барьцаа хөрөнгө 5 хувь байна. Барьцаа хөрөнгийг Барилгын тухай хуулийн 14.3, 14.4, 14.5 заасны дагуу үүргийн биелэлтийг дүгнэж олгоно”

⁵⁴ Төсвийн тухай хуулийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”

⁵⁵ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын 3.4.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хууль, журмын дагуу боловсруулан бэлтгэж тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах

⁵⁶ Дээрх журмын 8.5-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно.”

⁵⁷ Дээрх журмын 8.6-д “Энэхүү журмын 8.5-д заасан санхүүжилтийн эрхийн дагуу ОНХС-ийн төрийн сан дахь данснаас гүйлгээ хийх төлбөрийн хүсэлтийн баримтад аймаг, нийслэлийн хувьд 1 дүгээр гарын үсгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч, сум дүүргийн хувьд 1 дүгээр гарын үсгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг Засаг даргын Тамгын газрын ахлах нягтлан бодогч тус тус зурна.”

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг аймгийн хэмжээнд нэгтгэн судалж, тооцоогүй байна.

2.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөн хэрэгжүүлж буй зарим ТАХ-г хугацаанд нь гүйцэтгэж ашиглалтад оруулаагүйгээс бодит үр дүн бүрэн гарахгүй байна.

Аймгийн ОНХС-ийн шилжих хөрөнгө оруулалтын жагсаалтад 2021 онд эхлээд 2022 онд дуусах нийт 7 багт “Миний гудамж-бидний гэр” төслийн хүрээнд гэр хороололд баригдсан цэвэр, бохир усны төв шугамаас салбар шугам сүлжээ татах ажил батлагдаж, 2023 оны төгсгөлд 5 багийн ажил дуусаж, 2 багийн ажил 2024 онд дамжин хэрэгжихээр болсон. Үүнээс 1 ажил нь хэрэгжиж 1 ажил хэрэгжиж дуусаагүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх ихэнх ажил нь авто замын засвар, шинэчлэлтийн ажил бөгөөд зураг төсөв боловсруулах, аймгийн ИТХ-аар баталсан төсвийн дүнд үндэслэж төсвийг салгах, ХАА-г оройтож зарлах, олон дахин зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулах, шалгарсан оролцогчийн хугацаандаа ажил гүйцэтгээгүй байдал зэргээс шалтгаалж олон замын ажлууд он дамжин хэрэгжихээр байна.

Он дамжин хэрэгжиж буй авто замын засвар, шинэчлэлтийн ажлуудаас 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар нэмж 4 ажил бүрэн хийгдэж дууссан байна. Үүнд:

- Орхон аймаг. Баян-Өндөр сум. Яргуйт багийн "А" цэгээс "М" цэг хүртэлх 1.506 хатуу хучилттай авто зам
- Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уртын гол баг. 260 айлын орон сууцны 0.28 км авто зам шинээр барих.
- Орхон аймаг. Баян-өндөр сум. Баянбулаг баг. 18-р цэцэрлэгийн авто зогсоолд их засварын ажил хийх /үлдээгдэл хэсэг/
- Орхон аймаг. Баян-Өндөр сум. Булаг баг. Наран багийн 74-р гудамжны уулзвараас Булаг багийн уулзвар хүртэлх авто замд их засварын ажил хийх.

Эдгээр ажлуудаас бусад нийт 29 авто замын ТАХ хэрэгжиж дуусаагүй хэвээрээ байна. Тухайлбал дараах ажлуудыг гүйцэтгэл 2025.06.25 өдрийн байдлаар хангалтгүй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №4-өөс үзнэ үү)

1. Шилдэг зам ХХК-ийн гүйцэтгэж буй Орхон аймаг. Баян-Өндөр сумын 6 дугаар бичил хорооллын уулзвараас Их залуу багийн уулзвар хүртэлх А1002 дугаартай улсын чанартай авто замыг 4 эгнээ болгож өргөтгөн шинэчлэх ажил.

Анх байгуулсан гэрээний хугацаагаар 2024.10.11-нд дуусах байсан боловч 2025.07.01-ийг хүртэл гэрээг сунгасан. Төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр 2025.06.12-ны өдрийн байдлаар авто замын барилгын ажил 13.9 хувь, нүхэн гарцын ажил 51.8 хувийн гүйцэтгэлтэй сунгасан хугацаандаа орох боломжгүй.

2. Жи пи экспресс финанс ХХК-ийн гүйцэтгэж буй Орхон аймаг. Баян-Өндөр сум. Дэнж баг. Орон сууцны Баян-Өндөр, ББ парк хотхон орчмын хатуу хучилттай авто зам шинээр барих. Гэрээний хугацаа 2024.12.05-нд дуусах байсан боловч 2025.07.20-ийг хүртэл гэрээг сунгасан. Ажлын гүйцэтгэл 45 хувьтай.

3. Жавхлан харгуй ХХК-ийн гүйцэтгэж буй Орхон аймаг. Баян-Өндөр сум. Чингэл багийн авто замын төгсгөлөөс Ёс заншлын өргөө хүртэлх 1км хатуу хучилттай авто зам шинээр барих. Гэрээний хугацаа 2024.12.30-нд дуусаад 2025.07.15-ийг хүртэл сунгасан. Ажлын гүйцэтгэл 60 хувьтай.

4. Бумбат даваа ХХК-ийн гүйцэтгэж буй Улаантолгой багт асфальтан зам тавих ажил. Гэрээний хугацаа 2024.11.20-нд дуусаад 2025.08.28 хүртэл сунгасан. Ажлын гүйцэтгэл 20 хувьтай.

5. Хүчит зам ХХК-ийн гүйцэтгэж буй Орхон аймаг. Баян-Өндөр сум. Зэст баг. БОЭТ-ийн авто зогсоол , авто замд их засварын ажил хийх. Гэрээний хугацаа 2024.11.12-нд дуусаад 2025.07.08 хүртэл сунгасан. Ажлын гүйцэтгэл 90 хувьтай.

6. Ингүүмэл зам ХХК-ийн гүйцэтгэж буй Орхон аймаг. Баян-Өндөр сум. Зэст баг. 1-14-р байрны хойд талын тойргоос БОЭТ-ийн баруун урд талын уулзвар хүртэлх авто замд их засварын ажил хийх. Гэрээний хугацаа 2025.01.15-нд дуусаад 2025.08.12 хүртэл сунгасан. Ажлын гүйцэтгэл 20 хувьтай.



Орхон аймгийн Говил баг, 2-р цэцэрлэг, 2-р сургуулийн авто зогсоол шинээр барих ажлууд хийгдэж дууссан хэдий ч ус зайлуулагчийг зургийн дагуу бүрэн хийгээгүй байна.

Мөн 2-р цэцэрлэгийн гаднах авто зогсоолыг хүлээн авснаас хойш Эрдэнэт үйлдвэрийн цэвэр усны шугамын ажлыг хийхдээ гүүрэн гарцын хэсгийг эвдэн ажлыг гүйцэтгэсэн ч дахин засварлаж асфальтаар битүүлээгүй, хар шороо, чулуугаар хучилт хийсэн байна.



Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, аймгийн, сумдын Засаг дарга нар нь сумын ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний тоон болон чанарын хүрэх үр дүнг нэгтгэн тооцоогүй байна.

Баян-өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г хэт жижиглэж, олон арга хэмжээ болгож хуваан баталж байгаа нь ОНХС-ийн хөрөнгө оруулалтын үр ашиг, өгөөжийг бууруулж байна.

2.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн томоохон төсөл арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулж байна.

Аймгийн ОНХС-ийн төсвийг нэмэгдүүлэн Баян-Өндөр сумын насжилт өндөртэй авто замыг шинэчлэх ажлыг хийж байгаа нь хойшид иргэдийн тав тухтай амьдрах орчныг сайжруулах, өсөн нэмэгдэж байгаа хүн амын хэрэгцээ шаардлагыг хангах чухал ач холбогдолтой бөгөөд орон нутгийн хөгжилд үр нөлөө өгөхийц, үр

дүнд хүрч чадахаар чанартай гүйцэтгүүлэхэд захиалагч болон гүйцэтгэгч талууд харилцан онцгой анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Өмнөх онуудад төлөвлөж хэрэгжүүлж байсан сайжруулсан шороон зам нь гэр хорооллын тухайн гудамжны иргэдэд хэрэгтэй боловч, байгаль, цаг уурын нөхцөл байдалд тэсвэргүй, урт хугацаандаа үр дүн өгөхөөргүй төсөл арга хэмжээ болон хувирч байсан бол тайлант оноос иргэдийн үнэлэлтэд үндэслэн Баян-Өндөр сумын ОНХС-аас хэрэгжүүлж буй гэр хорооллын замын ажлыг 2 мөртэй зам болгон төлөвлөн хэрэгжүүлж байна.

Үүнээс гадна аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн томоохон ТАХ-үүд нь орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахуйц ажлууд байна. Тухайлбал:

Орхон аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн “Шанд багийн болон 17-р сургуулийн халаалтын системийг хийн зуухаар шинэчлэх” ажил анх удаа хийгдсэн нь халаалтын системийг нүүрсээр шийдвэрлэж байсныг хийн газар орлуулсан нь зардал хэмнэсэн төсөл болсон байна.

Мөн Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн 30 айлын орон сууц барьж ашиглалтад оруулсан мөн түрээсийн орон сууц бий болгох зорилготой хуучин барилгыг худалдан авч засварласан 12 айлын орон сууц бий болгосон нь сумын иргэдэд орон сууцанд орох эрэлтийг бий болгосон, зарцуулсан хөрөнгө нь эргэн төлөгдөх орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулсан үр нөлөөтэй хөрөнгө оруулалтын ажил болсон байна.

Улаантолгой багт цэцэрлэгт хүрээлэн байгуулсан нь сумын хөгжилд өнгө нэмсэн, иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх тав тухтай орчныг бий болгож байна.



Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр жил бүр төсвийн байгууллагуудын байрны засвар үйлчилгээ, хэрэгцээ шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах болон хөдөө аж ахуйн салбарт чиглэсэн техник, тоног төхөөрөмжүүдийг худалдан авах ажлууд хийгдсэн байна.

Харин Баян-Өндөр нь нийт 26 багтай 100 гаруй мянган хүн амтай аймгийн төвийн сум тул сумын ОНХС-ийн хөрөнгөөр багуудад орчны тохижилт, шинэчлэлт, камержуулалт, гэрэлтүүлэг хийх, гэр хорооллын багуудын усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх, төсвийн байгууллагуудад тоног төхөөрөмж худалдаж авах зэрэг хэт олон жижиг ТАХ-г хэрэгжүүлж байна.

Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлсэн Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уурхайчин баг. Уурхайчны тойргийн хэсгийн авто замд их засварын ажлын үлдэгдлийг хийх ажил нь асфальтын чанар технологи алдагдсанаас гүйцэтгэгчээр дахин засварлуулах нөхцөл байдал үүссэн байна.



Иймд гүйцэтгэж буй ажлын үе шатны ажлын чанарт анхаарахаас гадна мөн асфальт бетон хучилт буюу материалын чанарт хяналт тавьж, үргүй зардал, чанаргүй хөрөнгө оруулалтын арга хэмжээ болохоос сэргийлэх нь зүйтэй байна.

2.3 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй авто замын ажлууд бүрэн дуусаагүй тул ашиглалт хангалтгүй, бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалттай бус байна.

2.3.1 Төлөвлөсөн ажлуудыг цаг хугацаанд нь бүрэн ашиглалтад оруулахад хяналт, шахалт тавьж ажиллах шаардлагатай байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжиж дууссан, захиалагчийн хүлээн авсан ТАХ-г зориулалтын дагуу хэвийн ашиглаж байгаа хэдий ч зарим ТАХ ашиглах боломжгүй болж эвдэрсэн байна. Тухайлбал:

Жаргалант сумын ОНХС-ийн 2024 оны төлөвлөгөөнд баталсан болзошгүй аваарын зардлаас санхүүжүүлж 150.0 сая төгрөгийн шууд худалдан авалтаар ахмадын нийтийн тээврийн автобус авсан байна.



Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

Өмнөх онд мөн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар ахмадын тээвэрт хуучин автобус худалдан авсан нь нийтийн тээврийн шаардлага хангахгүй эвдэрч, эдэлгээний хугацаа дууссан тул актлахад хүрч хүчин чадлаар нь ашиглах боломжгүй, үр дүнгүй худалдан авалт болсон байна.

Баян-Өндөр сумын ОНХС-ийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Уурхайчин, Согоот багт замын голоор автомашин тусгаарлах хаалт хийх 2 ТАХ-нд нийт 28.0 сая төгрөг зарцуулсан нь эвдрээд ашиглах боломжгүй, үр дүнгүй хөрөнгө оруулалт болсон байна.



Хүснэгт 11 Орхон аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт.

(сая.төгрөг)

№	Аймаг, сумын нэр	Гэрээ байгуулсан		Бүрэн хэрэгжсэн		Дутуу хэрэгжсэн		Огт хэрэгжээгүй	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Баян-Өндөр сум	259	11,009.1	220	8,114.3	39	2,894.8	9	559.5
2	Жаргалант сум	124	13,120.5	120	10,661.7	4	2,458.8		
3	Орхон аймаг	103	68,932.8	62	22,177.7	41	46,755.1	1	122.0
Нийт дүн		486	93,062.4	402	40,953.7	84	52,108.7	10	681.5

Нэгдсэн судалгаанаас харахад аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн 681.5 сая төгрөгийн 10 ТАХ огт хэрэгжээгүй, 52,108.7 сая төгрөгийн 84 ТАХ дутуу хэрэгжсэн, 40,953.7 сая төгрөгийн 402 ТАХ бүрэн хэрэгжиж дууссан байна.

Нийт гэрээ байгуулсан ТАХ-ээс бүрэн хэрэгжсэн ТАХ тоогоор 82.7 хувьтай байгаа ч үнийн дүнгээр 44.0 хувьтай байна. Энэ нь өндөр дүнтэй он дамжин хэрэгжихээр төлөвлөгдсөн ажлууд болон авто замын засвар шинэчлэлтийн ажлуудын ХАА оройтож хийгдсэн, гэрээт хугацаандаа хэрэгжүүлж чадаагүйгээс он дамжин хэрэгжихээр болсонтой холбоотой байна.

2.3.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон нийтийн эзэмшлийн зарим ТАХ-ний хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалтын байдалтай танилцахад дараах зөрчил дутагдал илэрсэн. Үүнд:



Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хийгдсэн Уурхайчин баг. 8-р цэцэрлэгийн гадна тоглоомын талбай тохижуулах ажлын зарим хэсэг нь эвдэрсэн байна.



Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хийсэн Яргуйт баг. Хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажил эвдэрсэн байдалтай байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хийсэн Булаг баг. 25-р гудамжны тоглоомын талбайг тохижуулах ажлын гулгуурын хүүхэд унахаас хамгаалсан хаалт дутуу, савлуур хийгдээгүй байна.



Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хийсэн Уурхайчин баг. 1-р сургуулийн 3х3 сагсан бөмбөгийн талбайг байгуулах, "Сурагч лиг" 3*3 сагсан бөмбөгийн талбай байгуулах ажлуудын самбар, кольцо эвдэрсэн, ашиглах боломжгүй болжээ.

Нийтийн эзэмшлийн гудамж талбайд тохижуулсан хөрөнгийн хадгалалт, хамгаалалт орхигдсоор байна.

БҮЛЭГ 3. ОНХС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВЬЖ БУЙ ХЯНАЛТЫН ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙГЭЭС ЗӨРЧИЛ ДУТАГДАЛ АРИЛАХГҮЙ БАЙНА.

3.1 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ТАХ-нд тодорхой түвшинд хяналт хэрэгжүүлж буй боловч гүйцэтгэлийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, хяналтыг үр дүнтэй, оновчтой хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.1.1 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.2.2⁵⁸, 9.4⁵⁹-д ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон тус журмын хэрэгжилтэд чиг үүргийн дагуу хяналт тавих байгууллагуудыг тодорхой тусгасан байна.

Аймгийн ИТХ-аас Баян-өндөр, Жаргалант сумын ИТХ-д нийтийн сонсголын тухай хуулийн 9.3-д заасны хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад төсвийн хяналтын сонсгол хийх ажлыг зохион байгуулах тухай албан бичиг хүргүүлж сумдаас тайлан мэдээг авч сонсголын мэдээллийг аймгийн ИТХ-ын itkh.orkhon.gov.mn сайтад байршуулсан байна.

Баян-өндөр сумын 26 багууд дээр ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ажлуудаар нийтийн сонсгол хийж тайланг аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна. Харин Жаргалант сумын ИТХ нийтийн сонсгол хийгээгүй байна.

Аймгийн СХДАА-аас аймаг болон Жаргалант сумын ОНХС-ийн 2024 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитаар аймгийн ОНХС-д Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7 дугаар зүйл заалтуудын хэрэгжилтийг хангаж, тавих хяналтыг сайжруулах зөвлөж хүргүүлсэн боловч үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Жаргалант сумын ОНХС-д дараах 3 албан шаардлага, 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын зорилготой нийцэхгүй, иргэдийн санал аваагүй, эрэмбэд ороогүй ТАХ болон болзошгүй аваарын зардалд хөрөнгө батлан санхүүжүүлсэн үйл ажиллагаанд
- Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг огт оруулаагүй, дутуу оруулсан хөтөлбөр арга хэмжээний ажлын явц, гүйцэтгэлийг мэдээлээгүйд.

⁵⁸ ОНХС-ийн журмын 3.2-д "Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын чиг үүрэг", 3.2.2.Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих

⁵⁹ 9.4-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд ... хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина"

- Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг баталсан ч хэрэгжүүлсэн тайлан байхгүйд тус тус албан шаардлага өгч, байгууллагын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын бүх шаардлагыг мөрдөх, эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмж тус тус хүргүүлжээ.

Иймд дотоод аудитаас албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн асуудлаар энэхүү аудитаар зөрчлийг арилгах талаар давхардуулан шийдвэр гаргаагүй бөгөөд хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллах нь зүйтэй байна.

3.1.2 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж буй ч авто зам засвар, шинэчлэлтийн ажлуудын гүйцэтгэлийг бүрэн хангаж чадаагүй, зохион байгуулалт хангалтгүй, иргэдийн хүртэх үр өгөөж буурч байна.

Аймаг, сумдын ОНХС-аар санхүүжүүлж худалдан авсан бараа, материал, засварын ажлуудыг аймаг, сумдын ЗДТГ-аас болон ашиглагч байгууллагаас оролцсон ажлын хэсэг хүлээн авч, нийлүүлэлтэд хяналт тавьж, гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байна.

Барилга, байгууламж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажлуудад аймгийн “Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ-с захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, ажил тус бүрээр хяналтын инженер томилогдон, тухай бүрд ил далд ажлын актаар баталгаажуулж, гүйцэтгэлийн төсвийг гаргаж, санхүүжилтийг олгосон байна.

Мөн 2024 оны зам засвар, шинэчлэлтийн ажлуудад зөвлөх үйлчилгээгээр шалгарсан “Ар си эс си” ХХК, “Мөнхөд ашдын зам” ХХК-ууд техник технологийн хяналтыг давхар хэрэгжүүлэн ажиллажээ.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлж буй ажлуудын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаас хяналт хэрэгжүүлж буй хэдий ч замын ажлууд хугацаа хоцрох, он дамжин хэрэгжиж буй байдал гарсаар байгаа нь захиалагчийн хяналт хангалттай, үр дүнтэй, оновчтой хэрэгжиж чадахгүй байгааг илтгэж байна.

3.1.3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг 68.9 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас 2024 онд хийсэн ОНХС-ийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитаар аймгийн ИТХ-д 2, аймгийн Засаг даргад 3, сумдын Засаг дарга нарт 3, аймгийн ХБТХОХ-т 1 нийт 9 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хянан үзэхэд аймгийн ИТХ-д өгсөн шийдвэрийн хэрэгжилт 70 хувьтай, аймгийн Засаг дарга, ХБТХОХ-т өгсөн нийт 4 зөвлөмжийн хэрэгжилт 67.5 хувьтай, сумдын Засаг дарга нарт өгсөн зөвлөмжийг 70 хувьтай тус тус хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Тайлант онд ОНХС-ийн санхүүжилтийн хэмжээ огцом нэмэгдсэнтэй холбоотой зураг төсөв хийлгэх, магадлалын дүгнэлт гаргуулах, ХАА-г зохион байгуулахад хугацаа алдаж төлөвлөсөн ТАХ-үүд он дамжин хэрэгжих нөхцөл байдал үүссэн байна.

3.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам, зааврын дагуу тайлагнаагүй байна.

3.2.1 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтийг иж бүрэн тайлагнаагүй байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгүүлж тайлагнасан байна.

Сумдын ЗДТГ-н дарга нар ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй ТАХ-ний хэрэгжилтийн тайланг гаргаж аймгийн ЗДТГ-н ХБТХОХ-т хүргүүлээгүй нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан журмын 9.2⁶⁰-д заасантай нийцэхгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь журмын 9.3⁶¹, 9.9⁶²-д тусгасан ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум бүрээр гарган, дүгнэлт өгөөгүй, аймаг, сумын ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлээгүй байна.

Иймд ОНХС-ийн журмын 9.9-д тусгасан мэдээллийг бүрэн агуулсан тайланг нэгтгэн бэлтгэн гаргаж байх талаар зөвлөмж хүргүүлэв.

3.2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

ОНХС-аар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг холбогдох байгууллагын хөрөнгөнд бүртгэж байна. Харин он дамжин хэрэгжиж буй дуусаагүй ажлуудыг бүртгэл тайланд тусгаагүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй он дамжин хэрэгжих авто замын засвар, шинэчлэлтийн ажлуудыг ОНӨГ-т дуусаагүй барилгаар бүртгэсэн байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон 69,999.4 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд, 393.4 сая төгрөгийн хөрөнгийн бараа материалын дансанд бүртгэж, тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт зарцуулсан 6,416.3 сая төгрөгийг урсгал зардлаар хүлээн зөвшөөрч тус тус бүртгэсэн байна.

⁶⁰ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2-д “Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана”

⁶¹ 9.3-д “Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна”

⁶² 9.9-д “Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх ...”

3.2.3 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний 44.6 хувийг удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулаагүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.2 дахь заалтын дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнал, хяналт, бүртгэлийг аймаг, сумдын ЗДТГ нь удирдлагын мэдээллийн системд оруулах чиг үүрэгтэй.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 76,789.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 104, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 19,326.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 255, нийт 96,115.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 359 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталснаас удирдлагын мэдээллийн системд 55.4 хувь буюу 199 ТАХ-г бүрэн мэдээлж, 37.6 хувь буюу 135 ТАХ-г дутуу, 7 хувь буюу 25 ТАХ-г огт мэдээлээгүй байна.

Хүснэгт 12 УМС-д ТАХ-ний хэрэгжилтийг оруулсан байдал

(сая.төгрөг)

№	Аймаг, сумын нэр	УМС-д оруулбал зохих ТАХ-ний		Үүнээс:					
				Бүрэн оруулсан ТАХ-ний		Дутуу оруулсан ТАХ-ний		Огт оруулаагүй ТАХ-ний	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Баян-Өндөр сум	186	12,007.5	115	5,984.6	71	6,022.9		
2	Жаргалант сум	69	7,318.5	4	71.0	40	6,660.5	25	587.0
	Сумын дүн	255	19,326.0	119	6,055.6	111	12,683.4	25	587.0
1	Орхон аймаг	104	76,789.3	80	61,185.8	24	15,603.5		
	Нийт дүн	359	96,115.3	199	67,241.4	135	28,286.9	25	587.0

Дээрх хүснэгтийн огт оруулаагүй 25 ТАХ нь Жаргалант сумын ОНХС-тай холбоотой бөгөөд УМС-д мэдээллийг тухай бүр оруулах ажил хангалтгүй, зарим мэдээллийг сүүлд нь нөхөн оруулж байна.

- УМС-д аймаг, сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг оруулаагүй байхад ТАХ-ний санхүүжилтийг олгож байгаа нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 10.3.2⁶³-заасантай нийцэхгүй байх тул зөвлөмж хүргүүлэв.

ОНХС-ийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг дутуу болон зөрүүтэй оруулснаар иргэд, олон нийт нь үнэн зөв, бодитой мэдээллээр хангагдахгүй байна.

Иймд ОНХС-ийн мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор “Удирдлагын мэдээллийн систем”-д үнэн зөв, иж бүрэн оруулж хэвших шаардлагатай байна.

3.2.4 ОНХС-ийн төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд тухай бүр цаг тухайд нь мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 11 дүгээр хавсралтын хүрээнд

⁶³ 10.3.2-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн ОНХС-ийн УМС-ийн хэрэгжилт цэсэд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг хийнэ”

www.shilendans.gov.mn цахим хуудсанд ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг сар бүр болон бүтэн жилээр мэдээллийг байршуулахаар тусгайлан зааж өгсөн.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэхээр анх батлагдсан нийт 88 төсөл арга хэмжээний 71,241.6 сая төгрөгийн төлөвлөгөө, Баян-Өндөр сумын ОНХС-ийн 151 төсөл арга хэмжээний 10,781.0 сая төгрөгийн, Жаргалант сумын ОНХС-ийн 62 төсөл арга хэмжээний 15,128.4 сая төгрөгийн төлөвлөгөөг Шилэн дансны тухай хуулийн 6.1.1⁶⁴-д заасны дагуу хугацаанд нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байна.

Мөн аймгийн хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг сар бүр өссөн дүнгээр хугацаанд нь бүрэн оруулсан байна.

⁶⁴ Шилэн дансны тухай хуулийн 6.1.1-д “орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор мэдээлнэ”

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 1,230.1 сая төгрөгөөр дутуу олгосон байна.
- Аймгийн ОНХС-д “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас Засгийн газрын холбогдох шийдвэр болон хамтын ажиллагааны хүрээнд 55,361.0 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 25,361.2 сая төгрөг хүлээн авсан байна.
- Сумдад иргэдийн санал аваагүй 6,275.6 сая төгрөгийн 119 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан нь нийт шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний 48.6 хувийг эзэлж байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээний 92.1 хувь нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.
- Төсөвлөлтийн шаардлага хангахгүй буюу зураг, төсөв нь хийгдээгүй 42 ТАХ-нд 26,242.0 сая төгрөг төлөвлөж баталсан байна.
- Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хууль, журмаар тогтоосон чиг үүрэгт хамаарах ТАХ-г хэрэгжүүлэхээр тусгасан байна.
- Нийт төлөвлөсөн төсөл арга хэмжээний 98 хувьтай гэрээ байгуулж, 81 хувийг бүрэн хэрэгжүүлсэн, зарим ТАХ-ний гүйцэтгэлийн санхүүжилтийг илүү олгосон байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөн хэрэгжүүлж буй зарим ТАХ-г хугацаанд нь гүйцэтгэж ашиглалтад оруулаагүйгээс бодит үр дүн бүрэн гарахгүй байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн томоохон төсөл арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулж байна.
- Төлөвлөсөн ажлуудыг цаг хугацаанд нь бүрэн ашиглалтад оруулахад хяналт, шахалт тавьж ажиллах шаардлагатай байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон нийтийн эзэмшлийн зарим ТАХ-ний хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.
- Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж буй ч авто зам засвар, шинэчлэлтийн ажлуудын гүйцэтгэлийг бүрэн хангаж чадаагүй, зохион байгуулалт хангалтгүй, иргэдийн хүртэх үр өгөөж буурч байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг 68.9 хувьтай хэрэгжүүлсэн байна.
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтийг иж бүрэн тайлагнаагүй байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний 44.6 хувийг удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулаагүй байна.
- ОНХС-ийн төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд тухай бүр цаг тухайд нь мэдээлсэн байна.

Аудитаар нийт 1,650.6 сая төгрөгийн зөрчил⁶⁵ илэрснээс 433.4 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 1,190.3 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 26.8 сая төгрөгийн зөрчилд аймгийн 4 зөвлөмж өглөө.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад

Хууль, эрх зүйн хэлтэс:

- Бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх хугацааг хууль болон гэрээнд заасныг зөрчин үндэслэлгүйгээр гүйцэтгэгчид давуу байдал олгон сунгахгүй байх.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс:

- ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 8.5-д заасны дагуу ХБТХОХ-ээс ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ-ний санхүүжилтийн эрхийг олгох чиг үүргийг хэрэгжүүлэх
- ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.3, 9.9-т заасны дагуу сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум бүрээр гарган дүгнэлт өгөх, аймаг, сумын ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэн гаргаж байх.


Санхүү, төрийн сангийн хэлтэс:

- ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 10.3.2-д заасны дагуу ТАХ-ний хэрэгжилтийг УМС-д оруулсан мэдээлэлд үндэслэн санхүүжилтийг олгох

⁶⁵ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Холбогдох байгууллагын санал:

Тайланд тусгах саналгүй тул албан бичгүүдийг хавсаргав.



Хавсралтууд:

Хавсралт №1. Сумын хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээний жагсаалт (сая төгрөг)

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Он	Төсөвт өртөг
1. Жаргалант сум			
1	Жаргалант багийн гэрэлтүүлэг засварлах ажил	2024	20.0
2	“Ногоон - Жаргалант хөтөлбөрийн хүрээнд: Тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвасын хашааг зөөвөрлөх	2024	15.0
3	“Ногоон - Жаргалант хөтөлбөрийн хүрээнд:Газрын доройтол, цөлжилтийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	2024	18.0
4	Хойд хорооллын хүүхдийн тоглоомын талбайд тоглоом суурьлуулах, явган зам хийх	2024	20.0
5	Улаантолгой баг тасгийн хэсэгт цамхагт гэрэл хийх	2024	20.0
6	Жаргалант багийн зүүн талын малын худгийг ухаалга худаг болгох	2024	18.5
7	Улаантолгой багийн тариаланчдын 3-р гудамж байрлах гүний худаг ухаалга худаг болгох	2024	18.5
8	Улаантолгой багт тариалагчдын 14-р гудамжинд байрлах гүний худаг ухаалга худаг болгох	2024	18.5
9	СМТ болон ЭМТ-ийн гадна фасад болон гэрэлтүүлэг	2024	34.2
10	Ахмад залуучуудын ордныг түшиглэн тавилга эд хогшилоор хангаж заалыг тохижуулах	2024	20.0
11	Боловсрол хөтөлбөрийн хүрээнд: ЕБС-ийн багш нарт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2024	15.0
12	Боловсрол хөтөлбөрийн хүрээнд: Эрэгтэй технологийн кабинетад тавилга худалдан авах	2024	14.0
13	Малжуулах хөтөлбөрийн хүрээнд: Цөм сүргийн маллагаанд шаардлагатай мотоцикл худалдан авах	2024	6.0
14	Эрүүл Жаргалантчууд хөтөлбөрийн хүрээнд: Төрөх болон төрсний дараах, эхийн амрах өрөөнд тоног төхөөрөмж худалдан авах	2024	19.5
15	Малжуулах хөтөлбөрийн хүрээнд: / ХААЯ-наас 50% 2024 онд 50% 2025 онд шилжүүлэх нөхцөлтэйгээр шууд гэрээгээр Трактор 50 морины хүчтэй, дискэн хадуур, тармуур худалдан авах	2024	29.9
16	Боловсрол хөтөлбөрийн хүрээнд: Гар бөмбөгийн дугуйлангийн дагалдах хэрэгсэл болон сагс, волейболын бөмбөг авах	2024	7.5
17	Боловсрол хөтөлбөрийн хүрээнд: ЕБС-ын дотуур байрны панел солих, дотуур байрны арын хаалга,чийрэгжүүлэх өрөө болон гал тогооны арын хаалга солих, Эрэгтэй технологийн кабинетад ухаалаг дэлгэц худалдан авах	2024	14.9
18	Боловсрол хөтөлбөрийн хүрээнд: СМТөвд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, лед дэлгэцэнд бэхэлгээ хийх ажил	2024	4.8
19	Боловсрол хөтөлбөрийн хүрээнд: 3-р цэцэрлэгт бохир шугам лайдлах	2024	6.5
20	Эрүүл Жаргалантчууд хөтөлбөрийн хүрээнд: Хашааны төмөр автомат хаалга /1.6*5.0 м, авто тээврийн хэрэгсэл дугуй, амартизатор худалдан авах	2024	10.3
21	ЗДТГ-т Дрон худалдан авах	2024	20.0
22	Жаргалант, Улаантолгой багийн гэрэлтүүлэг сайжуулах ажлын хүрээнд гэрлийн толгой худалдан авах	2024	20.0
23	“Ногоон - Жаргалант хөтөлбөрийн хүрээнд: Жаргалант багийн орон сууцнуудын гадна талбайд модны тарьц суулгац худалдан авах	2024	20.0
24	ЗДТГ-ын мэргэжилтнүүдэд шаардлагатай зөөврийн компьютер авах	2024	20.0
25	“Ногоон - Жаргалант хөтөлбөрийн хүрээнд: Байгаль хамгаалах арга хэмжээний хүрээнд: Газрын доройтол, цөлжилтийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	2024	18.0
26	Жаргалант багт эрүүл мэндийн төвийн зүүн талаар явган зам хийх	2024	20.0
27	СМТ болон ЭМТ-ийн гадна фасадны гэрэлтүүлэг хийх	2024	44.1
28	Хойд хорооллын хүүхдийн тоглоомын талбайд тоглоом худалдан авах	2024	20.0

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

29	Болзошгүй аваарын зардал	2024	454.1
29	Жаргалант сумын дүн		967.3
2. Баян-Өндөр сум			
1	Баянцагаан баг. Пду-ийн Гэр хороололд баригдсан цэвэр, бохир усны шугамнаас салбар шугам үргэлжлүүлэн татах /Баянцагаан/	2024	469.0
2	Уртбулаг баг. 5-р хорооллын 24-р байрны нүхэн граж дээрх хүүхдийн тоглоомын талбай байгуулах /21-р байрны ард авто зогсоол хийх/	2024	310.3
3	Зэст баг. 1-р хорооллын 16,26-р байрны зорийн давхрын хэвтээ болон босоо шугам сүлжээг шинэчлэх	2024	206.8
4	Говил баг. Хонхорын хэсэгт байрлах 100 айлын төв шугамыг шинэчлэн засварлах	2024	205.5
5	Зэст баг. 1-6-р байрны явган зам шинэчлэх	2024	193.7
6	Хүрэнбулаг баг. 19-р цэцэрлэгийн дээвэр, дотор засвар хийх	2024	182.9
7	Оюут баг. "Дэгдээхэй" цэцэрлэгийн дээврийн засвар хийх	2024	179.0
8	Уурхайчин баг. 1-р сургуулийн 3х3 сагсан бөмбөгийн талбайг байгуулах	2024	178.1
9	Баянбулаг баг. 16-р сургуулийн өргөтгөлтэй холбох хүзүүвчний засвар хийх	2024	169.8
10	Наран багийн нийтийн эзэмшлийн зам, талбайн тохижилт хийх	2024	169.8
11	Баянцагаан багт. Багийн байрны дэргэд ухаалаг төхөөрөмж бүхий ус түгээх байр барих	2024	167.0
12	Уртын гол баг. Ус түгээх байр барих	2024	149.8
13	Уурхайчин баг. 7-р цэцэрлэгийн дээвэр, гал тогооны засвар хийх	2024	112.5
14	Булаг багийн 41, 42-р гудамжны харалдаа гүүр засварлах	2024	90.8
15	Уурхайчин баг. ДГТ-1, 2, 3-р байрны дулаан цэвэр усны шугам шинэчлэх	2024	87.1
16	Оюут баг. 2-р хорооллын 2-1 а, 2-1 б байрны дутуу хийгдсэн явган хүний замын ажлыг гүйцээх	2024	78.9
17	Бүрэнбүст баг. Орон сууцны 5-17, 5-18-р байрны дунд хүүхдийн тоглоомын талбай байгуулах	2024	49.0
18	Оюут баг. Орон сууцны 2А хороололд автобусны буудал шинээр барих	2024	48.0
19	Чингэл баг. Хабитатын хэсэгт автобусны буудал барих	2024	48.0
20	Баянцагаан баг. Эрх чөлөөний гудамжны хэсэгт автобусны буудал барих	2024	48.0
21	Баянцагаан баг. Авто вокзалын өмнө автобусны буудал барих	2024	48.0
22	Баянцагаан баг 9-р гудамжинд гарц хийх	2024	45.4
23	Согоот баг. Орон сууцны 6-р хорооллын 6-1,6-2-р байрны подвалын шугам засварлах	2024	35.4
24	Их залуу баг. Цагдаагийн кабоны засвар хийх	2024	29.5
25	Хүлэмжний газарт гүний худаг барих	2024	80.0
26	Дэнж баг. Баян-Өндөр хотхоны орцны кодтой хаалга хийх	2024	15.1
27	Согоот багийн орон сууцны байрнуудын хаяг дугаар сэргээн засварлах, нэмэх	2024	20.0
28	Цагаанчулуут багийн хаяг сэргээн засварлах	2024	20.0
29	Баянбулаг багийн сургууль, цэцэрлэгийн урд явган хүний гүүрэн гарц хийх	2024	10.3
30	Хүрэнбулаг багт автомашин тусгаарлах автомат хаалт хийх	2024	19.0
31	Булаг багийн айл өрхийн хаягжилт хийх	2024	19.0
32	Оюут баг. 8-р сургуулийн багш нарын өрөө засварлах	2024	18.0
33	Уурхайчин багт автомашин тусгаарлах хаалт	2024	9.0
34	Согоот багт автомашин тусгаарлах хаалт хийх	2024	19.0
35	Чингэл баг. Аврагчдын гудамжны хашааг гүйцээж хийх	2024	19.0
36	Бүсийн оношлогоо эмчилгээний төвд чих хамар хоолойн үзлэг болон төвөнхийн харалтын чанарыг сайжруулах зорилгоор иж бүрэн дуран бүхий үзлэгийн ширээ худалдан авах	2024	129.6
37	Антибиотекийн үлдэгдэл тодорхойлох оношлуур худалдан авах	2024	50.0
38	Багуудын ИНХ болон Ахмадын зөвлөлд шаардлагатай тоног төхөөрөмж, тохижилт	2024	40.0
39	Орхон аймгийн хоккейн холбоонд тохижилт, үйлчилгээ	2024	10.0
40	Багуудын бүлэг, хөршийн холбооны байр, гудамжны тохижилт, үйлчилгээ	2024	200.0
41	Баян-Өндөр суманд 40тн контейнер худалдан авах	2024	12.0

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

42	Орхон аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтэст Эталон төхөөрөмж, программ хангамж худалдан авах	2024	60.0
43	Дэнж багийн иргэний танхимд тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	10.0
44	Согоот багийн иргэний танхимын тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	18.7
45	Баянбулаг багийн иргэний танхимын бараа материал худалдан авах	2024	20.0
46	Оюут баг. 8-р сургуулийн багш нарын өрөөнд тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	20.0
47	Шанд багийн өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд тоног төхөөрөмж худалдан авах	2024	30.0
48	Зэст багийн иргэний танхимд тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	20.0
49	Эрдэнэ баг. Бүлэг хоршоо эрхлэгч, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд тоног төхөөрөмж худалдан авах	2024	91.1
50	Чингэл баг. Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд тоног төхөөрөмж худалдан авах	2024	77.6
51	Баян-Өндөр сумын сууц өмчлөгчдийн холбоодод хадуур худалдан авах	2024	36.0
52	Баян-Өндөр сумын иргэний танхимд тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	50.0
53	Согоот багийн өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд тоног төхөөрөмж худалдан авах	2024	50.4
54	Баян-Өндөр сумын брэнд бүтээгдэхүүний сав баглаа боодлыг сайжруулах	2024	19.9
55	Баянбулаг багийн иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжихэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2024	48.0
56	Рашаант баг. Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд тоног төхөөрөмж худалдан авах	2024	94.0
57	Яргуйт, Баян-Овоот багийн өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд тоног төхөөрөмж худалдан авах	2024	50.0
58	Хүрэнбулаг багийн сургууль, цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	49.1
59	Уртбулаг багт мод, бут худалдан авах	2024	17.0
60	Уртбулаг багийн тоглоомын талбайнд ногоон зүлэг худалдан авах	2024	15.0
61	Ногоон байгууламжийн хамгаалах хашлага, хайс худалдан авах	2024	10.3
62	1-р цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2024	20.0
63	Оюут баг. 5-р цэцэрлэгт шаардлагатай хивс, дроз худалдан авах	2024	20.0
64	Хүрэнбулаг баг. 10-р цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн ор худалдан авах	2024	20.0
65	4-р цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2024	20.0
66	24-р цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2024	20.0
67	Баянбулаг багийн гэрэлтүүлгийн нөхөлт хийж СИП кабель солих ажил	2024	20.0
68	Рашаант багийн иргэний танхимын тохижилт	2024	19.9
69	Рашаант багт хуванцар хог хаягдал цуглуулах сав худалдан авах	2024	19.7
70	5-р сургуульд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2024	19.0
71	Яргуйт, Баян-Овоот багийн иргэний танхимын тохижилт	2024	19.0
72	Уртын гол баг. Үйлсбадрах ӨЭМТ-д шаардлагатай УВЧ аппарат, тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	19.0
73	Оюут баг. Дэгдээхэй цэцэрлэгт шаардлагатай бараа материал худалдан авах	2024	20.0
74	3-р сургуулийн "Цахим танхим"-д шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	19.0
75	Шанд багийн цэцэрлэг, сургууль, ӨЭМТ-д шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2024	19.5
76	Баянцагаан багийн сургуульд шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	19.0
77	Зэст баг. Анхны-Оч ӨЭМТ-д тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	19.1
78	Ирээдүй-Одод сургуульд сурагчийн ширээ, сандал худалдан авах	2024	10.0
79	Уртбулаг багийн сургууль, цэцэрлэгт тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	19.0

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

80	Рашаант багийн өрхийн бичил үйлдвэрлэл эрхлэгчдэд тоног төхөөрөмж худалдан авах	2024	19.5
81	Даваат баг. Аялгуу соёлын төвд тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	14.0
82	Их залуу багийн иргэний танхимд тоног төхөөрөмж худалдан авах	2024	14.0
83	Говил багт гэрэлтүүлгийн кабель худалдан авах	2024	19.0
84	Хот тохижуулах газарт хогны сав худалдан авах	2024	25.1
85	Баян-Өндөр сумын ахмадын хороонд шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	10.0
86	Согоот багт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт	2024	11.0
87	Хүүхдэд зориулсан дижитал арт, график дизайны тоног төхөөрөмж худалдан авах	2024	18.0
88	Уурхайчин багт шаардлагатай камержуулалтын тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	19.0
89	Цагаанчулуут багт шилэн кабель худалдан авах	2024	18.0
90	Дэнж баг. Нарлаг дэнжийн АТП-20 дэд станцид 250кВА трансформатор худалдан авах	2024	19.0
90	Баян-Өндөр сумын дүн		5,308.2
119	Сумдын нийт дүн		6,275.6

Хавсралт №2 Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй төсөл арга хэмжээний жагсаалт. (сая төгрөг)

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Он	Төсөвт өртөг
1. Орхон аймаг			
1	Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдын үдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх /Эрдэнэт үйлдвэрийн 2024 оны хамтын ажиллагааны санхүүжилт /	2024	1,907.8
2	Иргэд, олон нийтийн дунд соёл, урлаг, спортын болон бусад арга хэмжээг зохион байгуулах /Эрдэнэт үйлдвэрийн 2024 оны хамтын ажиллагааны санхүүжилт /	2024	218.0
3	Залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ зохион байгуулах /Эрдэнэт үйлдвэрийн 2024 оны хамтын ажиллагааны санхүүжилт /	2024	82.0
4	Илгээлтийн эзэд анхдагчдад хүндэтгэл үзүүлэх зардал	2024	840.0
5	Аймгийн хэмжээнд ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх зардал	2024	1,428.0
6	Илгээлтийн эздийн 50 жилийн ойн хүрээнд барилгын цэргийн ахмадуудын дунд үйл ажиллагаа зохион байгуулах зардал	2024	150.0
7	Боловсрол, эрүүл мэндийн салбар болон төрийн анхан шатны нэгжүүдийн дунд хамтын ажиллагааг өргөжүүлэх олон талт үйл ажиллагааг илгээлтийн эзэд анхдагчдын байгууллагуудтай хамтран зохион байгуулах зардал	2024	122.0
8	Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд байгууллагууд ахмадууд, залуучуудын дунд хэлэлцүүлэг, сургалт зөвлөгөөн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зардал	2024	200.0
9	Илгээлтийн эздийн 50 жилийн ойн баяр, Хангай бүсийн хурдан морьдын уралдаан зохион байгуулахад уралдааны шагналд зарцуулагдах зардал	2024	200.0
10	Илгээлтийн эздийн 50 жилийн ойн медаль хийлгэх зардал	2024	60.0
10	Аймгийн дүн		5,207.8
2. Баян-Өндөр сум			
1	Их залуу баг. Цагдаагийн кабоны засвар хийх	2024	29.5
2	Дэнж баг. Баян-Өндөр хотхоны орцны кодтой хаалга хийх	2024	15.1
3	Анхдагч илгээлтийн эздийн холбооны байрны засвар	2024	10.0
4	Согоот багийн орон сууцны байрнуудын хаяг дугаар сэргээн засварлах, нэмэх	2024	20.0
5	Булаг багийн айл өрхийн хаягжилт хийх	2024	19.0
6	Уурхайчин багт автомашин тусгаарлах хаалт	2024	9.0
7	Согоот багт автомашин тусгаарлах хаалт хийх	2024	19.0

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

8	Багуудын ИНХ болон Ахмадын зөвлөлд шаардлагатай тоног төхөөрөмж, тохижилт	2024	40.0
9	Багуудын бүлэг, хөршийн холбооны байр, гудамжны тохижилт, үйлчилгээ	2024	200.0
10	Баян-Өндөр суманд 40тн контейнер худалдан авах	2024	12.0
11	Орхон аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтэст Эталон төхөөрөмж, программ хангамж худалдан авах	2024	60.0
12	Дэнж багийн иргэний танхимд тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	10.0
13	Согоот багийн иргэний танхимын тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	18.7
14	Баянбулаг багийн иргэний танхимын бараа материал худалдан авах	2024	20.0
15	Зэст багийн иргэний танхимд тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	20.0
16	Баян-Өндөр сумын сууц өмчлөгчдийн холбоодод хадуур худалдан авах	2024	36.0
17	Баян-Өндөр сумын иргэний танхимд тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах	2024	50.0
18	Ерөнхий боловсролын сурагчдад сурагчийн аюулгүй байдлын гарын авлага худалдан авах	2024	20.0
19	Баян-Өндөр сумын брэнд бүтээгдэхүүний сав баглаа боодлыг сайжруулах	2024	19.9
20	Яргуйт, Баян-Овоот багийн иргэний танхимын тохижилт	2024	19.0
21	Их залуу багийн иргэний танхимд тоног төхөөрөмж худалдан авах	2024	14.0
21	Баян-Өндөр сумын дүн		661.2
3. Жаргалант сум			
1	ЗДТГ-ын байранд хэсэгчилсэн засвар хийх	2024	150.0
2	ЗДТГ-ын байрны бүх цонх, хаалга солих	2024	120.0
3	СМТ болон ЭМТ-ийн гадна фасадны гэрэлтүүлэг хийх	2024	44.1
4	Эрүүл Жаргалантчууд хөтөлбөрийн хүрээнд: Хашааны төмөр автомат хаалга /1.6*5.0 м, авто тээврийн хэрэгсэл дугуй, амартизатор худалдан авах	2024	10.3
5	ЗДТГ-т Дрон худалдан авах	2024	20.0
6	ЗДТГ-ын мэргэжилтнүүдэд шаардлагатай зөөврийн компьютер авах	2024	20.0
7	Болзошгүй аваарын зардал	2024	454.1
7	Жаргалант сумын дүн		818.5
38	Орхон аймгийн нийт дүн		6,687.5

Хавсралт №3 Ажлыг зураг, төсөв хийлгээгүй баталсан авто замын завсар, шинэчлэлтийн төсөл арга хэмжээний жагсаалт (сая төгрөг)

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Дэнж баг. Орон сууцны Баян-Өндөр, ББ парк хотхон орчмын хатуу хучилттай авто зам шинээр барих.	2,058.0
2	Орхон аймаг. Баян-өндөр сум. Баянбулаг баг. 27-р цэцэрлэгийн тойргоос 16-р сургуулийн уулзвар хүртэлх авто замд их засварын ажил хийх.	567.7
3	Орхон аймаг. Баян-өндөр сум. Баянбулаг баг. Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын зогсоолоос Онцгой байдлын 81-р ангийн уулзвар хүртэлх авто зам, авто зогсоолд их засварын ажил хийх.	527.4
4	Орхон аймаг. Баян-өндөр сум. Баянбулаг баг. 18-р цэцэрлэгийн авто зогсоолд их засварын ажил хийх.	207.6
5	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Баянцагаан баг. ПДУ хэсгийн 1.16 км хатуу хучилттай авто зам шинээр барих.	987.9
6	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Булаг баг. Наран багийн 74-р гудамжны уулзвараас Булаг багийн уулзвар хүртэлх авто замд их засварын ажил хийх.	131.5
7	Орхон аймаг. Баян-өндөр сум. Бүрэнбүст баг. Эрх чөлөөний өргөн чөлөөний авто замаас 5-р сургууль хүртэлх авто зам, авто зогсоолд их засварын ажил хийх.	248.2

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

8	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Говил баг. 2-р сургуулийн авто зогсоол шинээр барих.	511.9
9	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Говил баг. 2-р цэцэрлэгийн авто зогсоол шинээр барих.	299.3
10	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Говил баг. Төв замаас Эрх бүжин цэцэрлэг, Ээж төв хүртэлх авто замд их засварын ажил хийх.	795.3
11	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Даваат баг. 17-р сургуулийн гадна талд хатуу хучилттай авто зогсоол шинээр барих.	499.7
12	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Даваат баг. 17-р сургуулийн уулзвараас Наран багийн 74-р гудамжны уулзвар хүртэлх авто замд их засварын ажил хийх.	734.3
13	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Дэнж баг. Сэтгэц мэдрэлийн эмнэлэгийн гадна талд хатуу хучилттай авто зогсоол шинээр барих.	265.1
14	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Зэст баг. 1-14-р байрны хойд талын тойргоос БОЭТ-ийн баруун урд талын уулзвар хүртэлх авто замд их засварын ажил хийх.	773.1
15	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Зэст баг. БОЭТ-ийн авто зогсоол , авто замд их засварын ажил хийх.	1,608.4
16	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Их залуу баг. 15-р сургуулийн баруун талын уулзвараас халуун усны уулзварын авто замд их засварын ажил хийх.	821.6
17	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Наран баг. 74-р гудамжны уулзвараас хорооллын эцэс хүртэлх авто замд их засварын ажил хийх.	1,535.6
18	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Оюут баг. Барилгачдын талбайн уулзвараас зүүн тийш 0.31 км авто замд их засварын ажил хийх.	272.6
19	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Оюут баг. Отгонбилэгийн гудамжны төв замаас 28,34-р байрны авто зогсоол , авто замд их засварын ажил хийх.	281.9
20	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Рашаант баг. 26-р цэцэрлэгийн баруун талын уулзвараас Халуун усны уулзвар хүртэлх авто замд их засварын ажил хийх.	789.2
21	Орхон аймаг. Баян-өндөр сум. Согоот баг. 5,25-р байрны авто зам, авто зогсоолд их засварын ажил хийх.	298.2
22	Орхон аймаг. Баян-өндөр сум. Согоот баг. 9,10-р байрны авто зам, авто зогсоолд их засварын ажил хийх.	416.1
23	Орхон аймаг. Баян-өндөр сум. Уртбулаг баг. 1-р байрны дундах авто зогсоолоос 19-р байрны авто зам хүртэлх авто зам, авто зогсоолд их засварын ажил хийх.	416.1
24	Орхон аймаг. Баян-өндөр сум. Уртбулаг баг.19-р цэцэрлэгийн уулзвараас Оросын элчингийн уулзвар хүртэлх авто замд их засварын ажил хийх	2,290.7
25	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уртын гол баг. 260 айлын орон сууцны 0.28 км авто зам шинээр барих.	235.6
26	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уурхайчин баг. Сувилалын хойд талын авто замаас ДГТ 3-3-р байр хүртэлх авто зам , авто зогсоолд их засварын ажил хийх.	259.8
27	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уурхайчин баг. Уран эгшиг сургууль ,17-р цэцэрлэгийн орчмын хатуу хучилттай авто зогсоол шинээр барих.	238.7
28	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уурхайчин баг. Уурхайчины гудамжийг А1001 замтай холбосон авто замд их засварын ажил хийх.	156.9
29	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уурхайчин баг. Уурхайчины тойргын хэсгийн авто замд их засварын ажил хийх.	213.7
30	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уурхайчин баг. Үйлчилгээний төвийн баруун зүүн талын авто зам ,авто зогсоолд их засварын ажил хийх.	213.1
31	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Хүрэнбулаг баг.Эрх чөлөөний өргөн чөлөөний авто замаас Эрдэнэт үйлдвэр ТӨХК-ийн захиргааны 1-р байрны авто зам, авто зогсоолд их засварын ажил хийх.	233.7
32	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Хүрэнбулаг. Татвар нийгмийн даатгалын барилгын баруун хойд талын авто замаас 11-р хороололын А хэсгийн авто замд их засварын ажил хийх.	630.9

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

33	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Хүрэнбулаг. Эрх чөлөөний өргөн чөлөөний авто замаас 4-14-р байрны зүүн талаар 0.2 км авто зам, авто зогсоолд их засварын ажил хийх.	342.2
34	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Цагаанчулуут баг. Онцгой байдлын 81-р ангийн уулзвараас Булаг багийн уулзвар хүртэлх авто замд их засварын ажил хийх.	685.9
35	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Цагаанчулуут баг. Хорооллын эцсээс 26-р цэцэрлэгийн баруун талын уулзвар хүртэлх авто замд их засварын ажил хийх.	507.9
36	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Чингэл багийн авто замын төгсгөлөөс Ёс заншлын өргөө хүртэлх 1км хатуу хучилттай авто зам шинээр барих.	1,378.3
37	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Шанд баг. 17-р сургуулийн уулзвараас морь барианы уулзвар хүртэлх " ПК 1+00 - ПК 4+26 " авто замд их засварын ажил хийх.	475.4
38	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Шанд баг. Их залуу шандын 20-р гудамжнаас 17-р сургуулийн уулзвар хүртэлх 0.78 км авто замд их засварын ажил хийх.	1,012.6
39	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Эрдэнэ баг. 20-р сургуулийн гадна талд хатуу хучилттай авто зогсоол шинээр барих.	436.6
40	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Яргуйт баг. А1002 замын уулзвараас 15-р сургуулийн баруун талын уулзвар хүртэлх авто замд их засварын ажил хийх.	874.7
Дүн		25,233.1

Хавсралт №4 Он дамжин хэрэгжих 29 авто замын засвар, шинэчлэлтийн төсөл арга хэмжээний жагсаалт (сая төгрөг)

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Гүйц. Хувь
1	Орхон аймаг. Баян-Өндөр сумын 6 дугаар бичил хорооллын уулзвараас Их залуу багийн уулзвар хүртэлх А1002 дугаартай улсын чанартай авто замыг 4 эгнээ болгож өргөтгөн шинэчлэх ажил	38%
2	Орхон аймаг. Баян-Өндөр сум, Орон сууцны хороолол доторх авто замын зураг төсөл (Цагаанчулуут баг, Орон сууцны 7 дугаар хорооллын авто замын сүлжээг А/1002 авто замтай холбох)	70%
3	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Оюут баг. Отгонбилэгийн гудамжны төв замаас 28, 34-р байрны авто зогсоол , авто замд их засварын ажил хийх.	60%
4	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Оюут баг. Барилгачдын талбайн уулзвараас зүүн тийш 0.31 км авто замд их засварын ажил хийх.	95%
5	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Зэст баг. БОЭТ-ийн авто зогсоол , авто замд их засварын ажил хийх.	90%
6	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Зэст баг. БОЭТ-ийн авто зогсоол , авто замд их засварын ажил хийх.	60%
7	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Хүрэнбулаг. Эрх чөлөөний өргөн чөлөөний авто замаас 4-14-р байрны зүүн талаар 0.2 км авто зам, авто зогсоолд их засварын ажил хийх.	40%
8	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Хүрэнбулаг. Татвар нийгмийн даатгалын барилгын баруун хойд талын авто замаас 11-р хороололын А хэсгийн авто замд их засварын ажил хийх.	40%
9	Орхон аймаг. Баян-Өндөр сум, Орон сууцны хороолол доторх авто замын зураг төсөл (Оюут баг, Орон сууцны 2А хорооллын авто замыг А1001 болон Эрх чөлөөний өргөн чөлөөний авто замтай холбох)	30%
10	Орхон аймаг. Баян-өндөр сум. Бүрэнбүст баг. Эрх чөлөөний өргөн чөлөөний авто замаас 5-р сургууль хүртэлх авто зам, авто зогсоолд их засварын ажил хийх.	10%
11	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Хүрэнбулаг баг. Эрх чөлөөний өргөн чөлөөний авто замаас Эрдэнэт үйлдвэр ТӨХК-ийн захиргааны 1-р байрны авто зам, авто зогсоолд их засварын ажил хийх.	40%
12	Орхон аймаг. Баян-өндөр сум. Согоот баг. 5, 25-р байрны авто зам, авто зогсоолд их засварын ажил хийх.	50%

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

13	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Эрдэнэ баг. 20-р сургуулийн гадна талд хатуу хучилттай авто зогсоол шинээр барих.	70%
14	Орхон аймаг. Баян-өндөр сум. Согоот баг. 9,10-р байрны авто зам, авто зогсоолд их засварын ажил хийх.	95%
15	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Дэнж баг. Сэтгэц мэдрэлийн эмнэлэгийн гадна талд хатуу хучилттай авто зогсоол шинээр барих.	80%
16	Орхон аймаг. Баян-өндөр сум. Уртбулаг баг. 1-р байрны дундах авто зогсоолоос 19-р байрны авто зам хүртэлх авто зам, авто зогсоолд их засварын ажил хийх.	0%
17	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Эрдэнэ баг. 20-р сургуулийн гадна талд хатуу хучилттай авто зогсоол шинээр барих /үлдэгдэл ажил/	60%
18	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Хүрэнбулаг баг . 24, 25-р байрны авто зам, авто зогсоолд их засварын ажил хийх. .	95%
19	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Чингэл багийн авто замын төгсгөлөөс Ёс заншлын өргөө хүртэлх 1км хатуу хучилттай авто зам шинээр барих.	60%
20	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Баянцагаан баг. ПДУ хэсгийн 1.16 км хатуу хучилттай авто зам шинээр барих.	80%
21	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Кувейтын гудамжны аюулгүйн тойргоос Эрдэнэ багийн уулзвар хүртэл 3.5 км хатуу хучилттай авто замын "ПК 15+70 - ПК 23+54" хүртэлх авто замд их засварын ажил хийх.	80%
22	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Наран баг. 74-р гудамжны уулзвараас хорооллын эцэс хүртэлх авто замд их засварын ажил хийх.	20%
23	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Зэст баг. 1-14-р байрны хойд талын тойргоос БОЭТ-ийн баруун урд талын уулзвар хүртэлх авто замд их засварын ажил хийх.	20%
24	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Говил баг. Төв замаас 48-р байр хүртэл авто зам шинээр барих.	80%
25	Орхон аймаг. Баян-өндөр сум. Баянбулаг баг. 27-р цэцэрлэгийн тойргоос 16-р сургуулийн уулзвар хүртэлх авто замд их засварын ажил хийх.	70%
26	Орхон аймаг. Баян-өндөр сум. Уртбулаг баг.19-р цэцэрлэгийн уулзвараас Оросын элчингийн уулзвар хүртэлх авто замд их засварын ажил хийх	15%
27	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Дэнж баг. Орон сууцны Баян-Өндөр , ББ парк хотхон орчмын хатуу хучилттай авто зам шинээр барих.	45%
28	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Кувейтын гудамжны аюулгүйн тойргоос Эрдэнэ багийн уулзвар хүртэл 3.5 км хатуу хучилттай авто замын "ПК 9+30-ПК 15+70" хүртэлх авто замд их засварын ажил хийх.	40%
29	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уурхайчин баг. Уурхайчины тойргийн хэсгийн авто замд их засварын ажлын үлдэгдлийг хийх	95%

Зөрчлийн нэгтгэл:

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/13 дугаар тушаалын хавсралт

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

№	Зөрчлийн товч утга	Дүн	Шийдвэр	Хариуцах байгууллага
1	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Наран баг. 74-р гудамжны уулзвараас хорооллын эцэс хүртэлх авто замд их засварын ажил хийх тендерт шалгарсан Ингүүмэл зам ХХК-ийн ирүүлсэн үнийн хөнгөлөлт тооцсон үнэ болох 1,516.2 сая төгрөгийн үнийн саналыг /цахим системд тооцсон/ үнэлгээний хороо үнийн хөнгөлөлтийг хасаагүй дүнгээр уг тендерт шалгаруулах дүгнэлт гаргаснаар Ингүүмэл зам ХХК-тай БЗА-136/24 дугаартай гэрээг 1,525.2 сая төгрөг буюу үнийн саналаас 9.0 сая төгрөгөөр илүү дүнгээр байгуулсан байна	9.0	Төлбөрийн акт	Аймгийн Засаг дарга
2	31 байршилд хийгдэх авто зам, засварын барилгын ажлын техник технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний ЗТБ-60/24 дугаартай гэрээ байгуулан замын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй Ар си эс си ХХК-д 13 ажил тус бүрийн гэрээнд тусгасан захиалагчийн хяналтын зардлыг хэтрүүлж буюу тухайн ажлын хувьд гэрээний дүнг хэтрүүлэн нийт 2.2 сая төгрөг илүү олгосон байна.	2.2	Төлбөрийн акт	Аймгийн Засаг дарга
3	Захиалагчийн техник хяналтын зардлыг техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид олгосонтой давхардуулан нийт 15 төсөл арга хэмжээний 124.1 сая төгрөгийн орон нутгийн техник хяналтын дансанд илүү шилжүүлсэн байна. Төсвийн тухай хуулийн 41.2.340, Сангийн сайдын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2.941-д заасантай болон ажил тус бүрийн гэрээний 1.2-д тусгасан гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна гэсэн зохицуулалттай нийцэхгүй байх тул төлбөрийн акт тогтоов.	124.1	Төлбөрийн акт	Аймгийн Засаг дарга
4	Орхон аймгийн Баяр наадам, Эрдэнэт хот, Эрдэнэт үйлдвэрийг бүтээн босгосон Илгээлтийн эзэд - 50 жилийн ойн баярын хүрээнд ахмадуудад олгосон урамшууллыг 103 иргэнд 13.5 сая төгрөг давхардуулан илүү олгосон байна.	13.5	Төлбөрийн акт	Аймгийн Засаг дарга
5	Орхон аймгийн Баяр наадам, Эрдэнэт хот, Эрдэнэт үйлдвэрийг бүтээн босгосон Илгээлтийн эзэд - 50 жилийн ойн баяраар цэргийн ёслол, зочин төлөөлөгч хүлээн авах шатахууны 0.3 сая төгрөгийг анхан шатн баримтгүй зарцуулсан байна.	0.3	Төлбөрийн акт	Аймгийн Засаг дарга
6	Орхон аймаг. Баян-Өндөр сум. Зэст баг. БОЭТ-ийн авто зогсоол, авто замд их засвар хийх ажлыг гүйцэтгүүлэхээр Хүчит зам ХХК-тай байгуулсан БЗА-114/24 дугаартай гэрээний үнийн дүнгийн 30 хувь болох 478.96 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр олгосон хэдий ч тухайн гүйцэтгэгчид давуу байдал үүсгэж, урьдчилгаа төлбөрийг тооцохгүйгээр 368.8 сая	368.8	Албан шаардлага	Аймгийн Засаг дарга

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

	төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилтийг дахин нэмж олгосон байна.			
7	Баян-Өндөр сумын татварын орлогын төлөвлөгөөнд малд ногдуулах албан татварыг 7.6 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч ОНХС-ийн эх үүсвэрт оруулж батлаагүй, малын тоо толгойн албан татвараар 2024 онд 19.5 сая төгрөг бүрдүүлснийг сумын ОНХС-д төвлөрүүлээгүй байна.	19.5	Албан шаардлага	Баян-Өндөр сумын Засаг дарга
8	Сумын хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 5,308.2 сая төгрөгийн 90 ТАХ нь иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй байна.	-	Албан шаардлага	Баян-Өндөр сумын Засаг дарга
9	Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ-ний жагсаалтад зураг төсөл хийлгэх зардал батлагдаагүй байхад тайлант онд шууд гэрээ байгуулан зураг төслийн зардалд нийт 223.6 сая төгрөг зарцуулсан байна.	223.6	Албан шаардлага	Баян-Өндөр сумын Засаг дарга
10	Жаргалант сум. Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцаар хангах төсөл арга хэмжээний 2 гүйцэтгэгчийн /үндсэн барилга Сигма-Эс ХХК – 273.9 сая төгрөг, гадна тохижилт Талст-Өргөө ХХК – 10.4 сая төгрөг/ чанарын баталгааны нийт 284.3 сая төгрөгийг баталгааны хугацаа дуусаагүй байхад гүйцэтгэгчид олгосон байна.	284.3	Төлбөрийн акт	Жаргалант сумын Засаг дарга
11	Жаргалант сум малын тоо толгойн албан татвараар 2024 онд 38.1 сая төгрөг бүрдүүлж, төлөвлөгөөнөөс давсан 0.74 сая төгрөгийг мөн ОНХС-даа төвлөрүүлээгүй байна.	0.7	Албан шаардлага	Жаргалант сумын Засаг дарга
12	Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн дараах ТАХ-ний худалдан авах ажиллагааг холбогдох хуульд нийцүүлэн зохион байгуулаагүй байна. Үүнд: 1. Жаргалант сумын ОНХС-ийн 2024 оны төсөвт “Улаантолгой багт цэцэрлэгт хүрээлэн байгуулах” ажилд 970.0 сая төгрөгийн төсөвт өртөг баталсан ч ХАА-г 1,290.2 сая төгрөгөөр тендер зарлан 1,282.7 сая төгрөгийн үнээр гүйцэтгэгчийг шалгаруулан 2024 онд 970.0 сая төгрөг, 2025 онд 312.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр ЖС-17/24 дугаартай гэрээг байгуулсан байна. 2. Жаргалант сумын ОНХС-ийн 2024 оны төсвийн тодотголоор “Малжуулах хөтөлбөрийн хүрээнд: ХААЯ-аас 50% 2024 онд 50% 2025 онд шилжүүлэх нөхцөлтэйгөөр шууд гэрээгээр Трактор 50 морины хүчтэй, дискэн хадуур, тармуур худалдан авах” нэртэй ТАХ-нд 29.9 сая төгрөг баталж тендер шалгаруулалтгүйгээр “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-аас 114.9 сая төгрөгөөр “Хөдөө аж ахуйн техник худалдах, худалдан авах” 20244462119126 дугаартай, гэрээнд тоног төхөөрөмжийн үлдэгдэл төлбөрт жилийн 5 хувийн хүү төлөх зохицуулалттай, гэрээ байгуулсан. 3. Болзошгүй аваарын зардлаас тендер сонгон шалгаруулалтгүйгээр шууд гэрээгээр 150.0 сая төгрөгөөр автобус худалдан авсан байна.	577.7	Албан шаардлага	Жаргалант сумын Засаг дарга
Нийт дүн		1,623.7		